

ЗАМ ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ

Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв



Төмөр замын хөдлөх бүрэлдэхүүний хөдөлгөөнийг хянах технологийг нэвтрүүлэх судалгаа, төсөл



ТӨМӨР ЗАМЫН ХӨДЛӨХ БҮРЭЛДЭХҮҮНИЙ ХӨДӨЛГӨӨНИЙГ ХЯНАХ ТЕХНОЛОГИЙГ НЭВТРҮҮЛЭХ СУДАЛГАА, ТӨСӨЛ



Гарчиг

ХУРААНГУЙ	3-4
НЭГ. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА	5-21
1.1 Төслийн суурь үзүүлэлтүүд	6
1.2 Төслийн үндэслэл	6
1.3 Төслийн зорилго, зорилт.....	8
1.4 Төслийн үр ашиг ач холбогдол, төсөл хэрэгжих үе шатууд	8
1.5 Төслийг судалсан байдал	9
1.6 Төсөл хэрэгжүүлэгчийн танилцуулга	10
1.6.1 Үндсэн хэрэгжүүлэгч: “Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулах нэгдсэн төв” УТҮГ	10
1.6.1.1 Бүтэц, зохион байгуулалт... ..	10
1.6.2 Бусад оролцогч: “УБТЗ” ХНН, “МТЗ” ТӨХК, “БТЕГ” ХХК	11
1.6.2.1. Монгол-Оросын “Улаанбаатар төмөр зам” ХНН	11
1.6.2.2. “Болд төмөр Ерөө гол” ХХК-ийн Баянголын төмөр зам	12
1.6.2.3. “Монголын төмөр зам” ТӨХК	14
1.6.3 Төсөл хэрэгжих байршил	14
1.6.4 Төслийн бүтээгдэхүүний танилцуулга	19
ХОЁР. ҮНДСЭН ХЭСЭГ	22-67
2.1. ГТХЗНТөвийн хөгжлийн үзэл баримтлал	23
2.2. Туршилтын дэд төсөл “Мини удирдлагын төв байгуулах”.....	26
2.2.1 Туршилтын төслийн хүрээнд хийгдэх ажиллагаа.....	26
2.3 Мини удирдлагын төв.....	27
2.3.1. Мини удирдлагын төвийн тоног төхөөрөмж, серверийн үзүүлэлтүүд.....	28
2.4. Хөрш орнуудын төмөр замын системүүд.....	31
2.5. Хөдлөх бүрэлдэхүүний хөдөлгөөн хяналтын тоног төхөөрөмжийн шийдэл.....	33
2.5.1. “VIS” Хөдлөх бүрэлдэхүүн тодорхойлох систем.....	33
2.5.1.1. Системийн тойм.....	33
2.5.1.2. Системийн тохируулга.....	34
2.5.1.3. Өгөгдлийн менежмент ба мэдээлэл авах терминалууд.....	41
2.5.1.4 Системийн ажиллагаа.....	41
2.5.1.5 Системийн үзүүлэлтүүд.....	42
2.5.1.6. “НТК”-ын “VIS” суурилуулалт ба газар шорооны ажил.....	43
2.5.1.7 Тоног төхөөрөмж суурилуулах хугацаа.....	47
2.5.2. OCR Camera хяналтын систем.....	47
2.5.3 “Шилэн кабель” онолын хэсгийн товч танилцуулга.....	50
2.5.3.1. Шилэн кабель ашиглан мэдээлэл дамжуулах, хүлээн авах.....	56
2.5.4 Өртөөдөөс мини удирдлагын серверлүү дамжих өгөгдлийн тооцоо.....	60
2.6 Ач холбогдол.....	60
2.6.1 Галт тэрэгний бүрэлдэхүүн хүлээн авах технологийн процесс.....	60
2.6.2 Галт тэргийг өртөөнөөс явуулах процесс.....	64
2.6.3. Төмөр замын мэдээлэл солилцоо, ашиглагдах холбооны төхөөрөмжүүд болон программ хангамж	64
2.6.4. Ашиглалтын ажлын үзүүлэлтүүдийн мэдээллийг автоматжуулах.....	66
2.6.5 Хүний нөөц талаас хялбарчлах.....	66
ГУРАВ. ШААРДЛАГАТАЙ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХЭМЖЭЭ	68-75
3.1 Төслийн хөрөнгө оруулалт.....	69
3.1.1 Төслийн туршилтын хувилбар А/ Мини удирдлагын төвийн тоног төхөөрөмж серверийн зардал төгрөг ₮/.....	69
3.1.2 Хөдлөх бүрэлдэхүүнийг хянах, шийдлүүдийн тоног төхөөрөмжийн зардал /Нэг өртөөний зардал/.....	71
3.1.3 Кабель сүлжээний зардал / төгрөг ₮/.....	72
3.1.4 Бусад зардлууд / төгрөг ₮/.....	73
3.1.5 Зардлын нэгдсэн хүснэгт / төгрөг ₮/.....	73
3.2 Төслийн үндсэн хувилбар Б	74

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ	77
ХАВСРАЛТ А. Хөдлөх бүрэлдэхүүний нэгдсэн бүртгэл тооллого	78-95
А.1 Ажлын хэсгийн тайлан.....	79
А.2 Ажлын хэсгийн бүрэлдэхүүн, ажилласан хугацаа.....	79
А.3 Хөдлөх бүрэлдэхүүний нэгдсэн бүртгэл тооллогын чиглэл.....	80
А.4 Хөдлөх бүрэлдэхүүний нэгдсэн бүртгэл тооллогын ажиллагааг тушаалын дагуу хамтран гүйцэтгэсэн аж ахуй нэгж, байгууллага.....	80
А.5 Төмөр замын тээврийн салбарын хөдлөх бүрэлдэхүүний бүртгэл.....	80
А.5.1 Төмөр замын тээврийн салбарт ашиглагдаж байгаа ачааны вагоны бүртгэл.....	81
А.5.2 Төмөр замын тээврийн салбарт ашиглагдаж байгаа зүтгүүрийн бүртгэл.....	82
А.5.3 Төмөр замын тээврийн салбарт ашиглагдаж байгаа суудлын вагоны бүртгэл.....	82
А.5.4 Төмөр замын тээврийн салбарт ашиглагдаж байгаа кран, зам засварын машин механизмын бүртгэл.....	82
А.5.5 “Улаанбаатар төмөр зам нийгэмлэг”-ийн хэмжээнд ашиглагдаж байгаа зам засварын машин механизмын бүртгэл.....	82
А.6 Хөдлөх бүрэлдэхүүний нэгдсэн бүртгэл тооллогоор аж ахуйн нэгжүүдэд илэрсэн зөрчлүүд.....	85
А.6.1 Нийтлэг зөрчил.....	85
А.6.2 Монгол-Оросын хувь нийлүүлсэн “Улаанбаатар төмөр зам нийгэмлэг”.....	88
А.6.3 Туулын гүүр Далай ХХК.....	91
А.6.4 “Дулааны 4-р цахилгаан станц” ТӨХК.....	91
А.7 Хөтөлийн “Цемент шохой” ХК.....	92
А.7.1 Объектын гэрчилгээ.....	93
А.7.2 Сонсголон бармат-ХК.....	93
А.7.3 Шарын гол ХХК.....	94
А.8 Дүгнэлт.....	95
А.9 Цаашид авах арга хэмжээний санал.....	95
ХАВСРАЛТ В. ОЛОН УЛСЫН ТӨМӨР ЗАМЫН АВТОМАТЖУУЛАЛТЫН СИСТЕМ	96-127
В.1. ОХУ-ын төмөр замын тээврийн удирдлагын автоматжуулалтын систем.....	97-117
В.2. БНХАУ-ын системүүд.....	118-127
ХАВСРАЛТ С. ӨРТӨӨДӨД ХИЙСЭН СУДАЛГААНЫ АЖЛЫН ТАЙЛАН	128-142
ЗУРГИЙН ЖАГСААЛТ	143
ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ	144

ЗАМ ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ
Галт Тэрэгний Хөдөлгөөн Зохицуулалтын Нэгдсэн Төв



Хураангуй

“Хөдлөх бүрэлдэхүүний хөдөлгөөн хянах технологи нэвтрүүлэх судалгаа төсөл”

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 129 дүгээр тушаалаар “Төмөр замын хөдлөх бүрэлдэхүүний хөдөлгөөн хянах технологи нэвтрүүлэх судалгаа, төсөл боловсруулах” 18 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байгуулагдан ажилласан.

Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх, үйл ажиллагаагаа бэхжүүлэхэд тус төсөл ихээхэн түлхэц үзүүлэх бөгөөд төмөр замын хөдлөх бүрэлдэхүүний хөдөлгөөнийг бодит цагаар тодорхойлох, өгөгдөлд дүн шинжилгээ хийх, ашиглалтын ажлын үзүүлэлтүүдийг бодит цагийн мэдээлэлд тулгуурлан тооцоолох, өгөгдлийн менежментийн нэгдсэн системд үндэслэсэн хэрэглэгчийн үйлчилгээг хялбаршуулах, төрийн хараат бус хяналтыг бий болгоход төслийн үндсэн зорилго оршино.

Мөн ГТХЗНТ-ийн одоо байгаа ажлын байранд 9 м² талбайд сервер байгуулах, 30 м² талбайд галт тэрэгний хөдөлгөөнийг бодит цагийн мэдээлэлд тулгуурлан тогтмол хянах мини өрөө байгуулахад шаардлагатай тоног төхөөрөмж, серверийн зардал, нэг өртөөнд суурилуулах тоног төхөөрөмжийн тооцоо, шилэн кабелийн шийдэл, цахилгаан хангамжийн тооцоо гэх мэт төсөлд холбогдох зардлуудыг тооцоолов.

Хөрш орнуудын төмөр замд өргөн ашиглаж байгаа галт тэрэгний бодит цагийн мэдээллийн VIS¹ болон OCR² системүүдийг ашиглан хөдлөх бүрэлдэхүүний хөдөлгөөнийг бодит цагаар тодорхойлох бөгөөд тус системүүд дээр үндэслэн төмөр замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, төмөр замын салбарын мэдээллийн нэгдсэн удирдлагын төв байгуулах үе шатуудыг тодорхойлов.

Монгол Улсын төмөр замын салбарын төрийн болон хувийн хэвшлийн хөдлөх бүрэлдэхүүн өмчлөгч, эзэмшигч нарын хөдлөх бүрэлдэхүүнийг нэгдсэн тооллогод хамруулж, програм хангамжид бүртгээд байна. Үүнээс “МТЗ” ТӨХК-ийн эзэмшлийн 185 хагас вагон, 10 битүү вагон, 50 тавцант вагонд RFID³ TAG суурилуулах, хилийн өртөөд Сүхбаатар, Замын-Үүд, болон Цагаан хаалга, Толгойт, Улаанбаатар, Сайншанд өртөөдөд RF⁴ дамжуулагч, уншигч нэгжүүдийг суурилуулах, “OCR” Camera системүүдийн аль тохиромжтойг сонгон суурилуулах турших талаар судалсан болно.

Мөн төслийн хүрээнд БНСУ-ын KOICA⁵-гийн Монгол дахь суурин төлөөлөгчийн газарт “ГТХЗНТ” УТҮГ-ыг бэхжүүлэх, галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй байдлын бодит цагийн

¹ Vehicle Identification system - Хөдлөх бүрэлдэхүүн тодорхойлох систем;

² Optical character recognition - Тэмдэгт таних камерийн хяналтын систем;

³ Radio frequency identification - Радио давтамжаар тодорхойлох;

⁴ Radio frequency - Радио давтамж;

⁵ Korean international cooperation agency – БНСУ-ын олон улсын хамтын ажиллагааны агентлаг

хяналт болон удирдлагын систем байгуулах” тусгай зориулалтын барилгыг ашиглалтад оруулах, хөдлөх бүрэлдэхүүнийг бодит цагаар хянах технологи нэвтрүүлэх зорилго бүхий төслийн үзэл баримтлалын баримт бичгийг боловсруулан 2019 оны 5 дугаар сарын 29-ний 126 дугаар тоот албан бичгээр ЗТХЯ-нд хүргүүлсэн.

Монгол дахь суурин төлөөлөгчийн газарт нийт 12-13 төсөл хүргэгдсэн бөгөөд 5 төсөл БНСУ дахь КОИСА-гийн төвд сонгогдоод байна. 2019 оны 9 дүгээр сарын 16-20-ны хооронд БНСУ-аас судалгааны баг ирж төсөл хэрэгжих шаардлагатай эсэхийг тодорхойлохоор ажилласан, 2020 оны 3 дугаар сард төмөр замын системийн талаар судалгаа хийж 8 дугаар сард төслийн шийдвэрийг мэдэгдэнэ. Төслийн хүрээнд 11 сая ам долларын буцалтгүй тусламж үзүүлэх боломжтойг бидэнд мэдэгдсэн.

БҮЛЭГ 1

Төслийн танилцуулга

НЭГ. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

1.1 Төслийн суурь үзүүлэлтүүд:

Хүснэгт 1.1. Төслийн суурь үзүүлэлтүүд

1	Төслийн нэр	Төмөр замын хөдлөх бүрэлдэхүүний хөдөлгөөнийг хянах технологийг нэвтрүүлэх судалгаа, төсөл
2	Төсөл хэрэгжүүлэх байгууллага	Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв УТҮГ /төслийг санаачлан боловсруулагч/, УБТЗ ХНН, МТЗ ТӨХК, БТЕГ ХХК
3	Хөрөнгө оруулалтын хэмжээ	Туршилтын дэд төсөл /А хувилбар/ - 1.585.332.00 төгрөг “VIS” суурилсан 2.110.780.080 төгрөг “OCR” CAMERA суурилсан Үндсэн төсөл /хувилбар Б / 11 сая ам доллар КОЙКА техникийн тусламж
4	Хөрөнгө оруулалтыг нөхөх хугацаа	-
5	Төлөвлөж буй хүчин чадал	Туршилтын А хувилбар МТЗ ТӨХК –ын хөдлөх бүрэлдэхүүн “TAG”-аар тоноглох, сонгогдсон 6 өртөөдөд уншигч нэгж суурилуулах Туршилт Б хувилбар Нийт хөдлөх бүрэлдэхүүнд “TAG” –аар тоноглох, 11 өртөөдөд уншигч нэгж суурилуулах.
6	Төлөвлөж буй үйлдвэрлэлийн хэмжээ	-
7	Нэгжийн шууд өртөг	“VIS” - Нэг өртөөнд суурилуулах уншигч нэгж -59.896 ам доллар Өгөгдлийн менежментийн систем -299.710.0 ам доллар Нэг ширхэг TAG – 39.0 ам доллар TAG бэхэлгээ -6,0 ам доллар “OCR”- Нэг өртөөнд суурилуулах кампанийн иж бүрдэл 88.624,4 ам доллар Програм хангамж – 250 .000,0 ам доллар
9	Дундаж үнэ	-
10	Орлогын хэмжээ	-
11	Төлөвлөж буй ашгийн хэмжээ	-

1.2 Төслийн үндэслэл

1.2.1. Хууль эрх зүйн хүрээнд:

Төмөр замын тээврийн тухай хууль:

14.1. Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв /цаашид “хөдөлгөөн зохицуулалтын төв” гэх/ нь төмөр замын байгууллагуудын галт тэрэгний хөдөлгөөнийг уялдуулан зохицуулах чиг үүрэгтэй.

14.3.2. Хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах зорилтын хүрээнд суурь бүтцүүдийн хоорондын галт тэрэгний хөдөлгөөнийг захирамжлан зохион байгуулж, зохицуулалт хийх;

14.3.3. Суурь бүтэц эзэмшигч хоорондын хөдөлгөөний удирдлага, зохион байгуулалтын харилцан уялдааг хангах;

14.3.6. Тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогч төмөр замын байгууллагын нэгдсэн технологийн горимыг боловсруулах;

- **Монгол Улсын Их Хурлын 2010 оны 32 дугаар тогтоолоор батлагдсан “Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого”:**
 - 1.2.1.5. төмөр замын салбарт бүтцийн шинэчлэлт хийж, төмөр замын тээврийн салбарын менежментийг боловсронгуй болгох;
 - 3.1.1. эдийн засгийн аюулгүй байдлын шаардлага: төмөр замын дотоодын нэгдсэн сүлжээ нь бодлогын хэрэгжилт, удирдлага, зохицуулалтын хувьд хараат бус байж, төмөр замын тээврийн өндөр үр ашигтай, алдагдалгүй нэгдсэн системийг бий болгон, эдийн засаг, дотоодын үйлдвэрлэгчдийг түүхий эдийн зах зээлийн үнийн хэлбэлзлээс хамгаалж, бие даан хөгжих үндэсний эрх ашгийг хангасан байх

- **Монгол Улсын хилээр нэвтэрч буй хөдлөх бүрэлдэхүүний бүртгэл хөтлөх, хүлээлцэх журам;**

1.3. Энэхүү журмыг Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, “Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв” улсын төсөвт үйлдвэрийн газар /цаашид “Хөдөлгөөн зохицуулалтын төв” гэх/, төмөр замын суурь бүтэц эзэмшигч, хөдлөх бүрэлдэхүүн эзэмшигч, төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогч иргэн, хуулийн этгээд дагаж мөрдөнө.

- Гуравдугаар бүлэг монгол улсын хилээр нэвтэрч буй хөдлөх бүрэлдэхүүнд тавигдах техникийн шаардлага
- Дөрөвдүгээр бүлэг монгол улсын хилээр хөдлөх бүрэлдэхүүн нэвтрүүлэх, бүртгэл хөтлөхөд тавигдах шаардлага
- Тавдугаар бүлэг монгол улсын хилээр нэвтэрч буй хөдлөх бүрэлдэхүүнийг хүлээлцэхэд тавигдах шаардлага



Зам, тээврийн хөгжлийн сайдын тушаал шийдвэрийн хүрээнд:

- Зам тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 129 дүгээр тушаал “Төмөр замын хөдлөх бүрэлдэхүүний хөдөлгөөн хянах технологийн судалгаа төсөл боловсруулах”.
- ГТХЗНТөвийн үр дүнгийн гэрээний 1.3.2-т заагдсан “Шаардлагатай цэгийг тодорхойлж хөдлөх бүрэлдэхүүнийг удирдан зохицуулах системийг хөгжүүлэх, төмөр замын хөдлөх бүрэлдэхүүний хөдөлгөөнийг хянах технологийн шийдлийг нэвтрүүлэх бэлтгэл ажлыг ханган хэрэгжүүлэх”.
- “Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв”-ийн барилгыг барих Нийслэлийн Засаг даргын “Газар эзэмшүүлэх эрхийг баталгаажуулах тухай” 2013 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн А/1053 тоот захирамжаар Баянгол дүүргийн 1 дүгээр хороонд 1262 м2 талбай бүхий газрын асуудал шийдвэрлэгдсэн.(Хавсралт №1,2)



2019 оны 9 дүгээр сарын 13 ны өдрийн Зам, тээврийн хөгжлийн сайдын тушаалаар шинэчлэгдэн батлагдсан төвийн дүрмийн хүрээнд:

4.3.5 Салбарын эрдэм шинжилгээ, судалгаа, инновацийг хөгжүүлэх дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх.

4.3.6 Төмөр замын тээврийн асуудал тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын өгсөн чиглэлийн дагуу болон төвийн санаачилгаар судалгааны ажил зохион байгуулах тайлагнах.

4.3.7 Төмөр замын байгууллагуудын мэдээлэл солилцох тогтолцоог боловсронгуй болгох.

4.3.9 Төвийн техник, технологи , автоматжуулалт мэдээллийн тасралтгүй найвартай, аюулгүй байдлыг хангах.

4.3.10 Төмөр замын байгууллагуудаас мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглах эдгээрт үндэслэн төвийн үйл ажиллагааг автоматжуулах.

4.3.11 Хөдлөх бүрэлдэхүүн, чингэлэг ашиглалтын бүртгэл, хяналтыг цахимжуулах,

4.3.13 Суурь бүтцүүдийн хэмжээнд тээврийн үйл ажиллагаанд ашиглах радио зурвасыг эзэмших, ашиглах,хуваарилах ажлыг судалж, холбогдох эрх зүйн бичиг баримтыг бүрдүүлж, хэрэгжүүлж ажиллах.

4.3.15 Төмөр замын тээврийн салбарын хүний нөөцийн чиглэлээр гаргасан бодлого, шийдвэрийг хэрэгжүүлэх, хүний нөөцийн нэгдсэн сан бүрдүүлэх хөтлөх.

4.3.18 Хөдлөх бүрэлдэхүүний бүртгэл хөтлөх, хүлээлцэх үйл ажиллагаатай холбоотой хяналтыг Монгол улсын хилээр нэвтэрч буй хөдлөх бүрэлдэхүүний бүртгэл хөтлөх хүлээлцэх журамд заасны дагуу зохион байгуулах.

1.3 Төслийн зорилго, зорилт

Зорилго 1:

Төмөр замын тээврийн салбарт суурь бүтэц, хөдлөх бүрэлдэхүүн, өмчлөгч эзэмшигч өсөн нэмэгдсэнтэй холбогдуулан галт тэрэгний хөдөлгөөнийг бодит цагаар тодорхойлох.

Зорилтууд:

- Олон улсын түвшинд амжилттай хэрэгжсэн хөдлөх бүрэлдэхүүний хөдөлгөөнийг тодорхойлох системийг нээн илрүүлэх;
- Ашиглахад хялбар энгийн бүтэц зохион байгуулалттай, үнэ хямд, ашиглалтын зардал бага шийдлийг судлах;
- Уг системүүдийг хөрш орнууд хэрэглэж байгаа эсэхийг тодорхойлох, улмаар хэрэгжүүлж буй институт, байгууллагатай холбогдох хамтран ажиллах;
- Төслийн хүрээнд туршилтын хөтөлбөр хэрэгжүүлэх, төсөвт өртөг тооцоолох;

Зорилго 2:

Суурь бүтэц эзэмшигч байгууллагуудын төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагаанд хэрхэн хяналт тавьж зохион байгуулж байгаа болон галт тэрэг солилцоо ачаа тээвэрлэлтийн уялдаа холбоог цахим системийн тусламжтай хянах, автоматжуулах боломжийг тодорхойлох.

Зорилтууд:

- Төмөр замын тээвэрлэлтэд хэрэглэгдэж буй програм хангамж, системүүдийг судлах;
- Хөдлөх бүрэлдэхүүний хөдөлгөөн хянах технологиудыг туршилтаар өртөөдөд нэвтрүүлэх, нэг өртөөнд суурилуулах зардлыг тооцох;
- Туршилт хийгдэх өртөөдөөс илгээгдэх өгөгдлийн мэдээллийг хүлээн авах боловсруулах, нэгдсэн систем хөгжүүлэх хатуу дэд бүтцийг суурилуулах; (мини хяналт удирдлагын төв)
- Салбарын хэмжээнд хөдлөх бүрэлдэхүүний хөдөлгөөн хянах технологийн шийдлийг суурилуулах зардлууд, систем хөгжүүлэлт, хатуу болон зөөлөн дэд бүтцийг хөгжүүлэх суурилуулах орон зайг бий болгох тусгай зориулалтын барилгыг ашиглалтанд оруулах хөрөнгө оруулалтыг шийдвэрлэх үр дүнтэй алхам хийх.

1.4 Төслийн үр ашиг ач холбогдол, төсөл хэрэгжих үе шатууд


Төслийн хүрээнд туршилтаар нэвтрэх хөдлөх бүрэлдэхүүний хяналтын шийдлүүдэд суурилсан мини хяналт удирдлагын төв байгуулах нь дараах ач холбогдолтой.

Үүнд:

- Төмөр замын салбарын бодит цагийн мэдээллийн нэгдсэн сан үүсэж, мэдээлэл хүлээн авах процесс бүрэн автоматчлагдах,
- Суурь бүтэц хоорондын галт тэрэг солилцоо болон хилээр өнгөрч буй хөдлөх бүрэлдэхүүнийг хянах боломж бүрдэх,
- Хяналт удирдлагын тодорхой шийдэлд хүрч үйлдвэрлэлд нэвтрүүлэх, суурилуулах ашиглах;
- Мини удирдлагын төвийн амжилттай туршигдсан загварыг ашиглан галт тэрэг найруулах төлөвлөгөөг оновчтой болгох, нийт хөдлөх бүрэлдэхүүнийг хянах 129 тушаалаар батлагдсан төслийг хэрэгжүүлэх;
- Хэрэглэгчийн үйлчилгээг сайжруулах;

Дэд төсөл хэрэгжүүлэх үе шатууд;

2021 онд туршилтын төсөл бүрэн хэрэгжиж дуусах бөгөөд төслийн үр дүнд үндэслэн үндсэн төслийг 2022-2025 онуудад хэрэгжүүлнэ.



Зураг 1.1. Дэд төсөл хэрэгжүүлэх хугацаа, үе шатууд

1.5 Төслийг судалсан байдал

Өмнө:

Ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг ОХУ, БНХАУ, Солонгос, Герман зэрэг орнуудын галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын төвүүдийн үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин, дүрэм журам, стандартыг судалж, 2012 онд Монгол Улсын ГТХЗНТ-ийн техник эдийн засгийн урьдчилсан судалгааг, 2016 онд ГТХЗНТ-ийн ТЭЗҮ боловсруулсан.

Одоо:

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 129 дүгээр тушаалаар батлагдсан “Хөдлөх бүрэлдэхүүний хөдөлгөөн хянах технологи нэвтрүүлэх судалгаа, төсөл” боловсруулах ажлын хэсгийн суурь судалгаа, мөн туршилтын дэд төсөл болох Мини удирдлагын төв байгуулах төслийг судалсан болно.

Цаашид:

- Хөдлөх бүрэлдэхүүний хөдөлгөөн хянах технологи нэвтрүүлэх, нэгдсэн систем бий болгох, дэд төслийг хэрэгжүүлэх, туршихтай холбогдуулан Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төвийг бэхжүүлэх, бодит цагийн хяналтын нэгдсэн систем бий болгох үүднээс БНСУ-ын “КОЙКА” олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгт төслийн үзэл баримтлалын баримт бичиг (РСР) боловсруулан 2019.05.29 өдөр хүргүүлсэн КОЙКА-гийн Монгол дахь төлөөлөгчийн газар хүргүүлсэн, улмаар 2019 оны 9 дүгээр сарын 16 – 20 -ны өдрүүдэд БНСУ дахь “КОЙКА”-ын төв байгууллагаас судалгааны баг ирж төсөл хэрэгжих шаардлагатай эсэхийг тодорхойлох судалгаа хийсэн. Уг төслийн санхүүжилтийн хэмжээ 11 сая ам доллар байх бөгөөд буцалтгүй тусламжийн хүрээнд төмөр замын хөдлөх бүрэлдэхүүн хянах технологид суурилсан хяналтын нэгдсэн систем бий болгох тусгай зориулалтын барилга байгууламж барих асуудлыг төслийн хүрээнд шийдэх боломжтойг Монгол дахь “КОЙКА” төлөөлөгчийн газар бидэнд мэдэгдэж, хамтран ажиллаж байна.
- Монгол Улсын Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төвийн галт тэрэгний удирдлага, хяналтын систем хөгжүүлэх
 - Галт тэрэгний хөдөлгөөний удирдлага, хяналтын системийн техникийн тодорхойлолтыг гаргах;

- Систем, сүлжээний загвар ба програм хангамж тохируулах. Тохиргоо болон загварыг үндэслэн техник хангамж, програм хангамжийг хөгжүүлэх, нэвтрүүлэх;
- Төмөр замуудад ашиглагдаж байгаа болон шинээр нэвтрүүлэх технологийг хөрш орны удирдлага, хяналтын системийн стандарттай нийцүүлэн, уялдуулах;
- Мэдээллийн технологийн дэд бүтэц ашиглах эзэмших, радио давтамжийн зурвас эзэмших, нарийвчилсан судалгаа хийх, төрийн захиргааны төв байгууллагаар эрх зүйн болоод шийдвэр гаргах түвшинд хэлэлцэх нэн шаардлагатай байна.

1.6 Төсөл хэрэгжүүлэгчийн танилцуулга

А. Үндсэн хэрэгжүүлэгч: Зам, тээврийн хөгжлийн яам, “Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв” УТҮГ

Б. Бусад оролцогч: “УБТЗ” ХНН, “МТЗ” ТӨХК, “БТЕГ” ХХК

1.6.1 Үндсэн хэрэгжүүлэгч: “Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулах нэгдсэн төв” УТҮГ

1.6.1.1. Бүтэц, зохион байгуулалт:

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 9 дүээр сарын 13-ны өдрийн 293 дугаар тушаалаар төвийн дүрэм, зохион байгуулалтын бүтцийг шинэчлэн баталж, зохион байгуулалтын **3** нэгж, **26** үндсэн, **3** гэрээт ажилтантайгаар үйл ажиллагаа явуулж байна



Зураг 1.2. ГТХЗНТ-ийн бүтэц зохион байгуулалт

Чиг үүрэг:

Төмөр замын тээврийн тухай хуулийн 14 дүгээр зүйлд дараах чиг үүргүүдийг тусгаж өгсөн:

- Төмөр замын сүлжээн дэх галт тэрэгний хөдөлгөөний удирдлага, зохион байгуулалтыг нэгдсэн удирдлагаар хангах, хянах чиг үүрэг.
- Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн удирдлагыг хэрэгжүүлэх, хянах ажиллагааг автоматжуулах чиг үүрэг.
- Салбарын эрдэм шинжилгээ, судалгаа, инновацийг хөгжүүлэх, үйлдвэрлэлийн тогтолцоог сайжруулж, тогтвортой хөгжүүлэх, галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй байдалтай холбоотой болон нэгдсэн удирдлагын төвийн стратеги төлөвлөлтийн судалгаануудыг хэрэгжүүлэх чиг үүрэг.

Бусад мэдээлэл:

Регистрийн дугаар: **5670225**

Санхүүгийн чадавх: **Улсын төсөвт үйлдвэрийн газар, жилийн дундаж санхүүжилт /600-700 сая төгрөг/**

Төслийн хамтрагчийн хөрөнгийн баталгаа: ГТХЗНТ УТҮГ БНСУ-ын “КОИСА” олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгт “Төмөр замын бодит цагийн хяналтын нэгдсэн систем хөгжүүлэх, ГТХЗНТ-ыг үйл ажиллагааг бэхжүүлэх” төслийн үзэл баримтлалын баримт бичгийг Монгол дахь “КОИСА” -гийн суурин төлөөлөгчийн газарт хүргүүлсэн. Бидний хүргүүлсэн төслийг дэмжих эсэхийг шийдвэрлэх хариу 2020 оны 8 дугаар сард эцэслэн мэдэгдэнэ. Боломжит санхүүжилтийн хэмжээ 11 сая ам доллар.

Төслийн ажилд үндсэн хоёр хувилбарт хөрөнгө оруулалт шаардлагатай гэж тооцсон.

Үүнд:

Хувилбар А: Сонгогдсон өртөөдөд туршилт хийхэд шаардагдах хөрөнгө оруулалт /Дэд төсөл/;

Хувилбар Б: Хяналтын шийдлүүдийг салбарын хэмжээнд нэвтрүүлэхэд шаардлагатай хөрөнгө оруулалт;

1.6.2 Бусад оролцогч: “УБТЗ” ХНН, “МТЗ” ТӨХК, “БТЕГ” ХХК

Манай орны төмөр замын түүхийн хуудас 1938 оноос эхлэн бичигджээ. Анх 1938 онд Улаанбаатар Налайхын хооронд нарийн царигийн төмөр зам тавигдсан. Мөн 1938-1939 онд Дорнод аймагт цэрэг стратегийн зориулалтаар Эрэнцав – Баянтүмэнгийн 268 гаруй км төмөр зам баригдсан. Цаашлаад **1949 онд Монгол Улсын хойд хилийг нийслэлтэй холбосон Наушки – Улаанбаатарын 400 км зам ашиглалтад орж энэ үеэс Монгол Оросын “УБТЗ ХНН” хувь нийлүүлсэн нийгэмлэгийн үйл ажиллагаа эхэлсэн.** Уг байгууллага 2008 оныг хүртэл дан ганцаар Монгол Улсын төмөр замын тээвэрлэлтийг гүйцэтгэн үйл ажиллагааны бодлого чиглэлийг тодорхойлсоор ирсэн.

Засгийн газрын 2008 оны 4 дүгээр сарын 09-ний өдрийн 134 дүгээр тогтоолоор Баянголын төмрийн хүдрийн орд газар хүртэл 98 км төмөр замын суурь бүтэц барих тусгай зөвшөөрлийг “Болдтөмөр Ерөө гол” ХХК-д олгосон. Сэлэнгэ аймгийн нутаг Ерөө өртөөнөөс Ерөө сумын Баянголын төмрийн хүдрийн ордын чиглэлд 98 км төмөр зам барих ажлыг 2008 оны 5 дугаар сарын 15-нд эхэлж 10-н сарын хугацаанд өөрийн хөрөнгийн эх үүсвэрээр барьж 2009 оны 9 дүгээр сарын 09-ний өдөр ашиглалтанд оруулсан анхны хувийн хэвшлийн төмөр зам юм.

Улсын Их Хурлын 2008 оны 35 дугаар тогтоол, 2010 оны 36 дугаар тогтоол, 2012 оны 37 дугаар тогтоол, **Засгийн газрын 2008 оны 153 дугаар тогтоол, 2014 оны 169 дүгээр тогтоолын хүрээнд “Монголын төмөр зам” Төрийн Өмчит Хувьцаат Компани** нь төмөр замын салбарт улсын төсөв болон гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр үүссэн өмчийг эзэмших, ашиглах, бизнесийн шударга өрсөлдөөнийг бий болгох, төмөр замын салбарт үндэсний компани бий болгох зорилгоор 2008 оны гуравдугаар сарын 05-ны өдрийн Монгол Улсын Засгийн газрын 82 дугаар тогтоол, мөн сарын 20-ны өдрийн Төрийн өмчийн хорооны шийдвэрээр байгуулагдсан.

Уул уурхайн металлургийн цогцолбор байгуулж, Дарханы төмөрлөгийн үйлдвэрийг өргөтгөх ажлын нэг хэсэг болох Төмөртэй ордоос Хандгайт өртөө хүртэл 33.4 км дэлгэмэл урттай төмөр замыг 2015 онд барьж, байгуулан эзэмшин ашиглаж байна.

Монгол Улсад төмөр замын тээвэр үүсч хөгжөөд 80 жил болж байна. Гэвч одоог хүртэл галт тэрэгний хөдөлгөөнийг удирдан зохицуулах, хянах, холбоо, дохиолол хориглолын байгууламжуудад 1970-1980 онд ашиглалтад орсон автоматик телемеханикийн системийг ашиглаж байна.


1.6.2.1. Монгол-Оросын “Улаанбаатар төмөр зам” ХНН

“УБТЗ” ХНН нь галт тэрэгний хөдөлгөөн зохицуулах 5 тойрогт хуваагдаж, галт тэрэгний зохицуулагч нь өртөө зөрлөгийн жижүүрт холбооны хэрэгсэл ашиглан, амаар захирамж өгөх байдлаар галт тэрэгний хөдөлгөөнийг зохион байгуулж байна. Өртөө зөрлөгүүдэд цахилгаан соронзон реле ашиглан хийгдсэн цахилгаан төвлөрүүлэлтийн (ДТХ) систем, харин хоорондын замд релейн хагас автомат хориглолын (РХАХ) систем ашиглаж байна. “Мандал” өртөө хүртэлх хойд хэсгийн жижиг өртөө, зөрлөгүүд суурин тэжээлтэй, төвийн хамааралтай /РЦЦМ/ системээр, том

өртөөнүүд блокон замнал релейн төвлөрүүлэлтийн системээр /БМРЦ/, харин төвийн ба урд хэсгийн өртөө, зөрлөгүүд БМРЦ ба блокон цахилгаан төвлөрүүлэлтийн /БЭЦ/ системээр тоноглогдсон.

Бүх хоорондын замууд нь хагас автомат хориглолын байгууламжаар тоноглогдсон. ХАХ-ын мэдээлэл нь шилэн кабелиар дамжигддаг.

УБТЗ ХНН 2013 оноос алсын удирдлагатай зөрлөгийг ашиглалтанд оруулах төслийг хэрэгжүүлж эхэлсэн. Алсын удирдлагатай зөрлөг гэдэг нь “ЕВІLOCK - 950” гэсэн микропроцессорын цахилгаан төвлөрүүлэлтийн системээр тоноглогдсон зөрлөг юм. Гол онцлог нь ийм зөрлөг дээр галт тэрэгний хөдөлгөөнийг удирдан явуулах зорилгоор өртөөний жижүүр ажиллах шаардлагагүй. Зэргэлдээ өртөөний жижүүр галт тэргийг явуулах, зөрүүлэх үйл ажиллагааг удирддаг байна. Энэ нь хүний хөдөлмөрийн үйл ажиллагааг хөнгөвчилсөн, эдийн засгийн хувьд хэмнэлттэй бөгөөд УБТЗ ХНН-д нэвтэрсэн хамгийн орчин үеийн төхөөрөмж байгууламж юм.



Зураг 1.3. УБТЗ ХНН -ийн сүлжээ

УБТЗ ХНН-ийн гол замд 2017-2019 онд нэвтрүүлэх чадварыг нэмэгдүүлэх, аюулгүй байдлыг хангах түвшинг дээшлүүлэх, системийн найдвартай байдлыг нэмэгдүүлэх, системийн гэмтлийн өмнөх байдалд нарийвчилсан оношилгоо хийх, ашиглалтын зардал бууруулах, төмөр замын тээврийн ажлын бүтээмжийг дээшлүүлэх, технологийн холбоо болон радио холбоог шинэчлэх зорилгоор радио хориглолын **СИРЦ-Е** системийг нэвтрүүлж байна.

Энэ төслийн хүрээнд 1111 км гол замын 68 өртөө зөрлөгт радио хориглолын 3 төв, диспетчерийн 5 тойрог, дамжуулах мэдрэгч 3610, гол тоологч мэдрэгч 118, бортовой систем 40 зэрэг тоног төхөөрөмжүүдийг шинээр тоноглож, сургалтын төв байгуулан ажиллахаар төлөвлөн ажиллаж байна.

1.6.2.2. “Болд төмөр Ерөө гол” ХХК-ийн Баянголын төмөр зам

“БТЕГ” ХХК нь УБТЗ ХНН-ын Ерөө өртөөнөөс “Баянгол” уурхай чиглэлд нийт 5 өртөө зөрлөг бүхий 98 км урт төмөр замтай. Төмөр зам дагуу 12 кор бүхий 105 км шилэн кабелиар дамжигддаг.




Модуль компьютерийн цахилгаан төвлөрүүлэлт: MCIS системийн тоног төхөөрөмжүүдийг Хятадын CONSEN автоматикийн компани үйлдвэрлэдэг. Модуль компьютерийн цахилгаан төвлөрүүлэлт буюу MCIS нь дараах төхөөрөмжүүдээс бүрдэнэ.

- Удирдах пулт
- Тэжээлийн байгууламж
- Кроссын зогсоогуур
- Хуваарилах зогсоогуур
- Төв зогсоогуур

MCIS системийн удирдах пулт. Уг системийг өртөөний жижүүр удирдах дэлгэц дээрээс удирдан явуулж галт тэрэгний хөдөлгөөнийг хянадаг.

Тэжээлийн байгууламж: Кроссын зогсоогуур. Хээрийн байгууламжаас ирж буй кабелийн судас болгон дээр аянга сарниулагч байрлана. Хуваарилах зогсоогуур. MCIS системийн хуваарилах зогсоогуурт хээрийн байгууламж болох сум, дохио, зам төмөр хэлхээг удирдах модулиуд байрладаг:

- Сумын модуль (ОС) — дан буюу тэлээ 2 бүлэг сумыг
- Дохионы модуль (ХН) - 1 оруулах, 2 гаргах, 4 сэлгээний дохиог
- Замын модуль (ОХУ) - 16 зам төмөр хэлхээг тус тус удирдах хүчин чадалтай



Зураг 1.5. MCIS системийн модулиуд

Хуваарилах зогсоогуураар модуль хоорондын холболт, тэжээлийн холболтууд, удирдлагын болон хяналтын хэлхээнүүд дамждаг. Мөн аналогийн дохиог тоон дохионд шилжүүлэх KJS-F485 хувиргагчууд байрладаг.

Сумын модуль: Сумууд 4 угаст хэлхээгээр ажиллах ба тус бүр дээр нь гал хамгаалагч байрласан байдаг. Тухайн сумууд ямар байдалд байгааг уг модуль дээр хянаж байдаг. Мөн модуль тус бүрийг хяналтын дэлгэцээс хянаж болдог.

Дохионы модуль: Дохионуудад 2 утаст лампыг хэрэглэдэг бөгөөд өөрийн лампыг хэлхээнээс гадна давхар хяналтын хэлхээтэй байдаг. Үүний тусламжтайгаар лампыг утас шатсан нөөц утсанд шилжсэн эсэхийг хянадаг. Мөн модуль тус бүрийг хяналтын дэлгэцээс харж болдог.

Замын модуль: Дохионуудад 2 утаст лампыг хэрэглэдэг бөгөөд өөрийн лампыг хэлхээнээс гадна давхар хяналтын хэлхээтэй байдаг. Үүний тусламжтайгаар лампыг утас шатсан нөөц утсанд шилжсэн эсэхийг хянадаг. Мөн модуль тус бүрийг хяналтын дэлгэцээс харж болдог.

Төв зогсоогуур: Төв зогсоогуурт MCIS системийн удирдлагын модуль, хуваарилах модуль, зохицлын модуль, ХАХ-ын модуль, хяналтын компьютер, UPS байрлана. Өртөө хоорондын хориглол буюу ХАХ-ын мэдээлэл нь шилэн кабелиар дамжуулагддаг.

1.6.2.3. “Монголын төмөр зам” ТӨХК

“Монголын төмөр зам” ТӨХК-ийн 23,4 км урттай Төмөртэйн төмөр зам нь 2016 оны 3-р сарын байдлаар галт тэрэгний хөдөлгөөний зохицуулалтаа “Болдтөмөр Ерөө гол” ХХК-ийн Баянголын төмөр замаар хэрэгжүүлж байна.

- Төмөр замын суурь бүтэц барих, ашиглах
- Төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагаа эрхлэх;
- Төмөр замын суурь бүтэц, хөдлөх бүрэлдэхүүнийг үйлдвэрлэх, угсрах, засварлах;
- Улсын төсвийн хөрөнгөөр болон гадаадын зээл тусламжаар төмөр замын салбарт үүсэн бий болсон хөрөнгийг эзэмшиж, ашиглах;
- Өөрийн хөрөнгөөр зүтгүүр, вагон, төмөр замын бусад объект, байгууламжийг худалдан авах, өмчлөлдөө бий болгох;
- Өөрийн эзэмшлийн хөрөнгийг тээвэрлэлтэд оролцогч бусад байгууллагад түрээсийн болон бусад гэрээгээр ашиглуулж орлого олох зэрэг үндсэн чиг үүрэгтэй ажиллаж байна.

1.6.3 Төсөл хэрэгжих байршил


Туршилтын дэд төслийн хүрээнд хөдлөх бүрэлдэхүүнийг хянах, байршил тодорхойлох, нэгдсэн хяналтын систем, бүртгэлийн нэгдсэн сан үүсгэх зорилгоор

- 1) OCR⁶ буюу AI⁷-д суурилан вагон дугаар тодорхойлж сургах, транзит вагон, дотоодын вагон хянах;
- 2) VIS⁸ радио давтамжид суурилан хөдлөх бүрэлдэхүүнийг бодит цагаар тодорхойлох системээр тус тус тоноглон сонгогдсон өртөөдөд туршилтаар нэвтрүүлнэ. Дараах зурагт тус систем нэвтрэх байршлыг харуулав:

⁶ Optical character recognition - Тэмдэгт таних камерын хяналтын систем;

⁷ Artificial intelligence – Хиймэл оюун

⁸ Vehicle Identification system - Хөдлөх бүрэлдэхүүн тодорхойлох систем;




Зураг 1.6. А хувилбар / Төсөл хэрэгжих байршил /

Тайлбар: Хилийн өртөөд : Сүхбаатар, Замын- Үүд

УБТЗ ХНН : Толгойт, Улаанбаатар, Сайншанд, /хамгийн их ачаалалтай ангигүй өртөөд /

Баянгол төмөр зам: Цагаан Хаалга өртөөдийг тус тус авав. /хилийн дамжуулах өртөө/

Хувилбар Б үндсэн төсөлд дараах өртөөдийг хөдлөх бүрэлдэхүүний хөдөлгөөн хянах тоног төхөөрөмжөөр тоноглоно.



Зураг 1.7. Б хувилбар / Төсөл хэрэгжих байршил /

Туршилт дэд төслийн хүрээнд дээрх 6 өртөөдөд хяналтын төхөөрөмж суурилуулан, хөдлөх бүрэлдэхүүний суурь өгөгдлийн мэдээллийг шилэн кабель, 4G LTE сүлжээгээр дамжуулан авах бөгөөд галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын төвд өгөгдлийн мэдээллийг боловсруулна.

Мөн “МТЗ” ТӨХК-ний хөдлөх бүрэлдэхүүнд хяналтын тоног төхөөрөмжийг суурилуулахаар төлөвлөж байна. Дараах хүснэгтэнд 2019 оны хөдлөх бүрэлдэхүүн тооллогын үр дүнгээс “МТЗ” ТӨХК-ийн хөдлөх бүрэлдэхүүнийг ялган харуулав.

Хүснэгт 1.2. Дотоодын вагон эзэмшигч байгууллагууд /“УБТЗ” ХНН вагонууд ороогүй болно/

Ачааны вагон эзэмшигчид		Тоо
БТЕГ ХХК	Хагас вагон	2996
МТЗ ТӨХК	<u>Хагас вагон</u>	<u>185</u>
	<u>Битүү вагон</u>	<u>10</u>
	<u>Тавцант вагон</u>	<u>50</u>
Хөтөл ХХК	Хоппер	114
Тэгш тэрмис ХХК	Битүү вагон	1
Анжелика ХХК	Битүү вагон	2
ТЗЗТИ ХХК	Хагас	359

Эрэл ХХК	Хагас	2
ТЭЦ – 4	Тавцант вагон	4
Сонсголон бармат ХХК	Думпкаар	36
Орчлон тулга ХХК	Думпкаар	2
Монцемент Билдинг Материалс ХХК	Хоппер	40
МАК цемент ХХК	Хоппер	182
Петролиум Продакшин	Цистерн	5
Туулын Гүүр Далай	Битүү вагон	7
Сангийн яаманд бүртгэлтэй	Хоппер вагон	57
Нийт		4001

Хүснэгт 1.3. Хөдлөх бүрэлдэхүүн түрээслэгч байгууллагуудын жагсаалт

Түрээслэгч	ХБ тоо	Төрөл	Эзэмшигчийн байгууллага
Дархан төмөрлөгийн үйлдвэр	359	хагас вагон	
Талын хишиг ХХК	185	хагас вагон	Төмөр замын зураг төслийн институт
<u>Сентурия Монгу ХХК</u>	<u>140</u>	<u>хагас вагон</u>	<u>МТЗ ТӨХК</u>
Тээвэр зуучийн төв	8	хагас вагон	БТЕГ ХХК
Туулын гүүр далай ХХК	7	хагас вагон	РЖД
SBL logistics ХХК	6	хагас вагон	РЖД
УБТЗ ХНН	3	зүтгүүр	МТЗ ТӨХК
	5	зүтгүүр	РЖД
Хөтөлийн Цемент Шохой ХХК	1	зүтгүүр	Мөнгөн хөдөлгүүр
Шарын Гол ХХК	1	зүтгүүр	БТЕГ ХХК
Нийт	715		

Хүснэгт 1.4. Аж ахуй нэгжүүдийн зүтгүүрийн бүртгэл

№	Аж ахуйн нэгжийн нэрс	Илчит тэрэгний сери, дугаар	Сэлгээний илчит тэрэг	Гол замын илчит тэрэг	Акт хүлээг дэж байгаа зүтгүүрийн тоо
1	“УБТЗ” ХНН	“УБТЗ” ХНН	22	-	-
		ТЭМ18	1	-	-
		ТЭМ18ДМ	11	-	-
		2М62М	-	14	13
		2М62ММ	-	16	-
		М62УМ	-	13	-
		Даш7	-	2	-
		2 Загал	-	10	-
		2ТЭ116	-	2	-
		2ТЭ116УМ	-	31	-
		2ТЭ116УД	-	4	-
		ТГМ23В	2	-	-

		2ТЭ25KM	-	5	-
Тус бүр			36	91	
Нийт илчит тэрэгний тоо			127		
2	“МТЗ” ТӨХК	2ТЭ116	=	2	=
		EVOLUTION	=	1	=
		CKD4b	=	5	=
		DF7g	1	=	=
Тус бүр			1	8	
Нийт илчит тэрэгний тоо			9		
3	“БТЕГ” ХХК	ТЭМ2	3	-	-
		CKD4b	-	12	-
Тус бүр			3	12	
Нийт илчит тэрэгний тоо			15		
4	“Эрдэнэт Уулын баяжуулах ТӨХК үйлдвэр”	ТЭМ2	3	-	
5	“Эрдэнэтийн дулааны цахил -гаан станц” ТӨХК	ТЭМ2	2	-	
6	“Шарын Голын Уурхай” ХХК	ТЭМ2	2	-	1
7	УБ хотын “Дулааны 4-р цахилгаан станц”	ТЭМ2	3	-	
8	“Багануурын Нүүрсний уурхай”	ТЭМ2	3	-	
9	“Хөтөл Цемент Шохой”	ТЭМ2	1	-	1
10	“Монгол Алт” ХХК	ТЭМ2	1	-	-
11	“Бор-Өндөрийн Уулын баяжуулах үйлдвэр”	ТЭМ2	2	-	1
12	“Мөнгөн хөдөлгүүр” ХХК	ТЭМ2	1	-	
13	“Транскон” ХХК	CKD9c	-	1	-
Тус бүр			18	1	-
Нийт илчит тэрэгний тоо			57	112	-
			170		16

Нийт 245 ш вагон, гол замын 8 зүтгүүр, сэлгээний 1 ш зүтгүүр байгаагаас 3 ш зүтгүүрийг “УБТЗ” ХНН-т түрээслэж бөгөөд тус хөдлөх бүрэлдэхүүнд хяналтын технологийг суурилуулж турших, хянах үйл ажиллагаа хийгдэнэ.


Үндсэн төслийн хүрээнд Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 128 дугаар тушаалаар томилогдсон ажлын хэсэг өгөгдсөн удирдамжийн дагуу Монгол Улсын төмөр замын тээвэрлэлт оролцож буй хөдлөх бүрэлдэхүүний нэгдсэн бүртгэл тооллого хийж, хөдлөх бүрэлдэхүүний техникийн баримт бичиг, гэрчилгээг газар дээр нь тулгах, шалгах, хөдлөх бүрэлдэхүүний ашиглалт, хадгалалтай холбоотой үйл ажиллагааг бүртгэлжүүлэх зорилгоор

2019.05.15-наас 2019.06.07-ны өдөр төмөр замын хөдлөх бүрэлдэхүүн ашиглаж байгаа аж ахуйн нэгжийн хөдлөх бүрэлдэхүүний нэгдсэн тооллогыг хийсэн. Төрийн болон төрийн бус 24 компанийн нийт 7489 ачааны вагон, “УБТЗ”ХНН-ийн үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 342 зорчигчийн вагон, 127 зүтгүүр, бусад аж ахуй нэгжийн 42 зүтгүүр, зам засврын машин механизм 42, мөн Сангийн яаманд бүртгэлтэй 8 замын машин бүртгэгдсэн нийт “VIS” системийн 10000 ширхэг “TAG”-аар дээрх хөдлөх бүрэлдэхүүнүүдийг тоноглоно.

Хөдлөх бүрэлдэхүүн тооллогын тайланг /Хавсралт 2/ харна уу.

1.6.4 Төслийн бүтээгдэхүүний танилцуулга

Үндсэн 4 төвшинд төслийн бүтээгдэхүүний цар хүрээг дараах диаграмаар харуулав.



Зураг 1.8. Төслийн бүтээгдэхүүн

Технологийн шийдэл


- ✓ Радио давтамжид суурилсан систем нь хөдлөх бүрэлдэхүүний бодит цагийн байршил тодорхойлох, вагоны суурь мэдээллүүдийг мэдээллийн технологи ашиглан “Төмөр замын мэдээллийн нэгдсэн систем”-ийг өгөгдлийн мэдээллээр /бодит цагийн мэдээлэл/ хангах төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагааг автоматжуулах, хялбаршуулах зориулалттай.
- ✓ Тэмдэгт таних, тодорхойлох Камерын тусламжтай хөдлөх бүрэлдэхүүний байршил тодорхойлох систем нь Монгол улсын төмөр замын сүлжээгээр дамжин өнгөрч буй хөдлөх бүрэлдэхүүнийг хянах зориулалттай.

Төмөр замын дотоодын вагоныг бодит цагаар тодорхойлох “VIS” систем:



Зураг 1.9. Радио давтамжид суурилсан шийдэл

Транзит вагоны хяналтын шийдэл



Зураг 1.10. AI⁹-д суурилсан вагон дугаар таних камерийн хяналтын систем


➤ **Системийн шийдэл**

Олон улсад болоод хөрш орнуудад тээвэр логистикийн нэгдсэн систем тэр дундаа төмөр замын салбарын нэгдсэн менежментийн систем нэвтрүүлэх, хөгжүүлэх асуудлыг онцгой анхаарч ирсэн. Дижитал буюу тоон систем нь цаг үеийн хөгжлийн явцад харилцаа холбооны салбараас бусад аж үйлдвэр, худалдаа, тээвэр гэх мэт салбаруудад эрчимтэй нэвтэрч үйл ажиллагааг автоматжуулах,

⁹ Artificial intelligence – ухаалаг оюун

бодит цагийн мэдээлэлд тулгуурласан шийдвэр гаргалт, хяналт, төлөвлөлт, зохион байгуулалтыг илүү уян хатан үр дүнтэй явуулах, үйл ажиллагааны зардлыг бууруулах боломжийг олгодог.

Дараах диаграмд төслийн хүрээнд хөгжүүлэх Төмөр замын бодит цагийн систем болон ирээдүйд хөгжүүлэх системүүдийн талаар харуулав.



Зураг 1.11. Бодит цагийн мэдээллийн урсгал бүтэц, зохион байгуулалт

Улаан зураасаар тэмдэглэсэн хэсэг нь төслийн хүрээнд гол зам дагуух хэсэгт “VIS” системээр тоноглон RRIS¹⁰ суурь системийг хөгжүүлж хөдлөх бүрэлдэхүүний хөдөлгөөнийг бодит цагаар тодорхойлно. Мөн ухаалаг өртөө байгуулах эхлэл болно.

Цэнхэр зураасаар депу, салбар замд зориулсан “VIS”-ээр тоноглон ухаалаг депу хөгжүүлэх, хөдөлгөөний аюулгүй байдлыг тодорхойлох бусад төрлийн уншигч, мэдрэгч сенсоруудыг тус суурь системд нэгтгэх боломжтой.

➤ Бизнес модель

Төслийн хүрээнд үнэ хэрэглэгчид үзүүлэх үйлчилгээ /бодит цагийн мэдээллээр хангах /, төмөр замын тээврийн байгууллагуудын үйл ажиллагааг автоматжуулах хүнээс бий болох алдааг багасгах, цахим системд суурилсан бизнес загвар шаардлагатай бөгөөд төсөл хэрэгжүүлэх ач холбогдол үнэ цэнэ, хэрэглэгчийн сегмент, борлуулалтын суваг, түншлэл, орлого зарлагын бүтэц зэрэг төслийг ерөнхий байдлаар нь харах боломжтой бизнесийн канвас загварыг харна уу.

Түлхүүр гүнш	Түлхүүр үйл ажиллагаа	Үнэ цэнэ	Хэрэглэгчтэй тогтоох харилцаа	Хэрэглэгчийн сегмент
<ul style="list-style-type: none"> Төрийн захиргааны төв байгууллага “Улаанбаатар төмөр зам” ХНН Монголын төмөр зам ТӨХК БТЕГ ХХК “КОЙКА” олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг 	<p>Хяналт, Шинжилгээ, Судалгаа, Зөвлөмж, Зохион байгуулалт, Систем хөгжүүлэлт, Цахим үйлчилгээ;</p> <p>Түлхүүр нөөц</p> <ul style="list-style-type: none"> Нэгдсэн систем Технологи МТ-ийн дэд бүтэц МТ-ийн мэргэжилтнүүд Тоног төхөөрөмж суурилуулах орон зай 	<ul style="list-style-type: none"> Хэрэглэгчийн үйлчилгээ хялбаршуулах Төмөр замын тээврийн үйл ажиллагааны зардал багасгах Хүнээс үйлдэлтэй алдаа багасгах /автоматжих/ Төрийн хараат бус бодит цагийн хяналт бий болох Бодит цагийн мэдээлэлд тулгуурласан дүн шинжилгээ хийх 	<p>Мэдээллийн технологи</p> <p>Борлуулалтын суваг</p> <p>Хөдлөх бүрэлдэхүүний хөдөлгөөн хяналтын бодит цагийн нэгдсэн систем, хэрэглэгчид үйлчлэх олон талт платформ хөгжүүлэлт,</p>	<ul style="list-style-type: none"> Төмөр замын тээвэрлэлттэй холбоотой 200 гаруй байгууллага Суурь бүтэц эзэмшигч байгууллагууд Төмөр замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага Хөрш орны төмөр замын хөдөлгөөн зохицуулалт, мэдээллийн хяналт удирдлагын төвүүд Масс хэрэглэгч
<p>Зардлын бүтэц</p> <p>Барилга угсралт - 3 сая ам доллар</p> <p>Суурь тоног төхөөрөмж - 2 сая ам доллар</p> <p>Хөдлөх бүрэлдэхүүний хөдөлгөөний хяналтын шийдэл - 6 сая ам доллар</p>		<p>Орлогын урсгалууд</p> <p>Төслийн хүрээнд БНСУ-ын төмөр замын салбарт амжилттай хэрэгжсэн бизнес загварыг нутагшуулах, цахим шилжилтэд тулгуурласан хэрэглэгчийн үйлчилгээг бий болгож төрийн үйлчилгээг халбаршуулах, бие даасан орлогын эх үүсвэрийг бий болгох судалгааг хамтран хийх;</p>		

Зураг 1.12: Төслийн бизнесийн канвас загвар

¹⁰ Railway Real-Time information System – Төмөр замын бодит цагийн мэдээллийн систем;

БҮЛЭГ 2


Үндсэн хэсэг

2.1. ГТХЗНТөвийн хөгжлийн үзэл баримтлал

Төмөр замын шинэ бүтээн байгуулалт, үүнтэй зэрэгцэн төмөр замын тээврийн хувийн болон төрийн өмчит байгууллагууд нэмэгдэх бөгөөд эдгээрийн тээвэрлэлтийн үйл ажиллагааг зохицуулан, харилцан уялдаа бий болгох зайлшгүй шаардлага бий болж байна. Иймээс галт тэрэгний нэгдсэн удирдлагын төв зайлшгүй шаардлагатай болно.

БНХАУ-ын Харбины төмөр замын товчооны харьяа хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв нь 6931 км төмөр зам, 494 өртөөдийг нэгдсэн удирдлага зохион байгуулалтаар хангаж ажилладаг 28900 м квадрат талбайд эрчим хүч, дохиолол холбооны тоног төхөөрөмжөөр тоноглогдсон бөгөөд 140 сая ам долларын хөрөнгө оруулалт хийгдсэн байдаг.

Бид олон улсын жишигт нийцэхүйц төмөр замын хөдөлгөөн удирдлагын нэгдсэн төвтэй болохын тулд төрөөс төмөр замын тээврийн салбарт баримтлах бодлогын бичиг баримтад тусгагдсан шинэ төмөр замын төслийн 3 түвшний бүтээн байгуулалтыг хэрэгжүүлж дуусгах, өөрөөр хэлбэл 5000 гаруй км төмөр замын сүлжээний урттай болсон үед нэгдсэн удирдлагын төвийг ашиглалтад оруулах нь ашигтай буюу үр дүнтэй юм. Доорх зурган дээр ГТХЗНТ-ийн хөгжлийн үе шатыг харуулсан, үүнд R&D¹¹ судалгааны арга зүйг дэлгэрүүлбэл:




Зураг 2.1. Төмөр замын бүтээн байгуулалтад төвийн үзэл баримтлал (2019-2035)

Хүснэгт 2.1. “ГТХЗНТ” УТУГ-ын хөгжлийн үе шат, үзэл баримтлал

Үе шат	I үе шат	II үе шат	III үе шат
Хугацаа	2019-2024 он	2025-2031 он	2031-2035 он

¹¹ Research and Development – Судалгаа хөгжүүлэлт;

Хүрэх түвшин	Нэгдсэн хяналтын суурь системийг бий болгох.	Олон талт платформ бий болгох	СТС хөгжүүлэлт
Дэд түвшин	<p>1. Монгол улсын хэмжээнд нийт хөдлөх бүрэлдэхүүнийг хянах тогтолцоог бий болгох</p> <p>2. Төмөр замын тээвэрт оролцогч төр, хувийн хэвшлийн байгууллагуудыг бодит цагийн суурь мэдээллээр хангах системийг хөгжүүлэх.</p> <p>3. Мини удирдлагын өрөө байгуулах турших.</p> <p>4. Өгөгдөл боловсруулах, мэдээллийн нэгдсэн төвийг ашиглалтад оруулах ,</p> <p>5. Олон улсын төмөр замын судалгааны байгууллагуудтай хамтран ГТХЗНТ-ийг ирээдүйн олон улсын жишигт нийцэхүйц төвийн хөгжлийн стратегийг боловсруулах, R&D судалгаа хөгжүүлэлтийн загварыг нэвтрүүлэх, хамтарсан судалгааны нэгж байгуулах.</p>	<p>1. Төмөр замын тээврийн байгууллагуудыг нэгдсэн олон талт системээр хангах.</p> <p>Тухайлбал:</p> <ul style="list-style-type: none"> • Хүний нөөцийн нэгдсэн систем • Галт тэрэгний үндэсний лавлагааны систем • Санхүүгийн менежментийн систем • Төмөр замын тээврийн байгууллагуудын хөрөнгийн менежментийн систем • Хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах систем: <ul style="list-style-type: none"> – Хос дугуйн гэмтэл илрүүлэх систем – Гүүшин халалт илрүүлэх систем – Зам төмрийн гэмтэл илрүүлэх систем – Ухаалаг өртөө хөгжүүлэх систем – Ухаалаг депо хөгжүүлэх – Галт тэрэг найруулах дижитал систем <p>2. Нэгдсэн системийг бусад салбарын системүүдтэй нэгтгэх.</p> <p>Гааль, авто тээвэр, татвар, даатгал гэх мэт</p> <p>3. Холимог тээвэрлэлт, чингэлэг тээвэрлэлтийг хянах, логистик үйл ажиллагааг нь хялбаршуулах, үр ашигтай тээвэрлэлтийг зохион байгуулах системийг хэрэглэгчдэд санал болгох.</p> <p>4. Хөрш орнуудын ижил төрлийн байгууллагуудтай мэдээлэл солилцоог бий болгож хилийн үзлэгийн хугацааг багасгах.</p>	<p>R&D-д суурилсан галт тэрэгний хөдөлгөөнийг шууд удирдах, “Нэгдсэн удирдлагын төв” буюу “СТС” байгуулах, хөгжүүлэх,</p>



Зураг 2.2. ГТХЗНТ-ийн R&D хөгжүүлэлт

Үндэслэл:

Бүтээгдэхүүний шинэ загвар, хөгжүүлэлт нь компанийн оршин тогтнох чухал хүчин зүйл болдог. Маш хурдан өөрчлөгдөж буй дэлхийн аж үйлдвэрийн хөгжлийн хувьд өөрсдийн загвар, бүтээгдэхүүний нэр төрлийг байнга шинэчилж байх ёстой. Хэрэглэгчдийн хувьсан өөрчлөгдөж буй хэрэгцээнээс шалтгаалан ширүүн өрсөлдөөн бий болж байгаа нь R&D хөтөлбөргүй байгууллагууд бусад шинэлэг зүйлийг олж авахын тулд стратегийн холбоо тогтоох, инновац худалдан авалтад татагдан орохоос аргагүйд хүрнэ.

Маркетингт суурилсан бүтээгдэхүүн хөгжүүлэлтийн систем нь хэрэглэгчийн эрэлт хэрэгцээг хамгийн түрүүнд тавьж, бренд бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэлд түлхүү анхаардаг. Үүнд тулгуурлан зах зээлийн олон талт судалгааг явуулдаг бөгөөд энэ нь хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээ, шинэ бүтээгдэхүүний боломжит зах зээлийг тогтоодог. Хэрэв бүтээгдэхүүн хөгжүүлэлт нь технологид тулгуурласан бол R&D нь хангагдаагүй хэрэгцээг хангах бүтээгдэхүүн үйлдвэрлэлд чиглэгдэнэ.

Ерөнхийдөө судалгаа, хөгжүүлэлтийн үзэл баримтлалыг үндэстэн дамнасан корпорацуудад харьяалагддаг мэргэжлийн нэгжүүд эсвэл төвүүд явуулдаг. Мөн гэрээт судалгааны байгууллага, их дээд сургууль, төрийн агентлагууд хэрэгжүүлдэг. Нийлүүлэлтийн хэлхээний менежментийн хүрээнд "судалгаа, хөгжүүлэлт" нь ихэвчлэн шинжлэх ухаан, технологийн ирээдүйд чиглэсэн, урт хугацааны үйл ажиллагааг хэлдэг.

2018 онд R&D хөгжүүлэлтэд хөрөнгө оруулалтаараа тэргүүлсэн компаниудын жагсаалт:

- Amazon: \$22.6 тэрбум
- Alphabet, Inc.: \$16.2 тэрбум
- Volkswagen: \$15.8 тэрбум
- Samsung: \$15.3 тэрбум
- Intel: \$13.1 тэрбум
- Microsoft: \$12.3 тэрбум
- Apple: \$11.6 тэрбум
- Roche: \$10.8 тэрбум
- Johnson & Johnson: \$10.6 тэрбум
- Merck: \$10.2 тэрбум

Төвийн ерөнхий үзэл баримтлалын хувьд олон улсын төмөр замын судалгааны институттай хамтран R&D судалгааны нэгж байгуулан CTC хөгжүүлэх стратегийг боловсруулан ажиллана.


2.2. Туршилтын дэд төсөл “Мини удирдлагын төв байгуулах”

2.2.1 Туршилтын төслийн хүрээнд хийгдэх ажиллагаа:

Нэг өртөөн дээр суурилуулах тоног төхөөрөмж, зардал, өгөгдөл дамжуулах шилэн кабель түрээс, ГТХЗНТ-ийн одоо байгаа байран дээр мини удирдлагын өрөө байгуулах үүнд шаардлагатай хяналтын дэлгэц, өгөгдөл хадгалах сервер зэрэг тоног төхөөрөмжүүдийн тооцоо суудалгааг тооцсон болно. Дараах зурган дээр хөдлөх бүрэлдэхүүний хөдөлгөөн хяналтын системээс “мини удирдлагын төв” буюу өгөгдлийн менежментийн төврүү өгөгдөл илгээх урсгалыг харуулсан бөгөөд ингэхдээ шилэн кабелийн сүлжээ ороогүй байршилд 4G LTE хэрэглэхээр тооцон өгөгдлийн урсгалын бүтэц зохион байгуулалтыг харуулав.




Зураг 2.3. Төслийн үйл ажиллагааны чиглэл



Зураг 2.4. Өгөгдлийн урсгал

2.3 Мини удирдлагын төв

Төслийн хүрээнд мини удирдлагын төвийг одоо байгаа оффисийн байранд тоноглон хэрэгжүүлэх бөгөөд доорх зурагт үзүүлсний дагуу “А” буюу хяналтын удирдлагын хэсэг “В” буюу серверт өгөгдөл хүлээж авах хадгалах боловсруулах хэсгүүдээс бүрдэнэ.



Зураг 2.5. ГТХЗНТ-ийн барилгын бүтэц зохион байгуулалтын зураг

А хэсэг байрлах тоног төхөөрөмжийн бүрдэл: Нийт 5x6 буюу 30² талбайг хяналтын дэлгэц суурин компьютерээр тоноглон ажиллана. Хяналтын 2 ажилтан, Серверийн ажиллагааг хянах 1, Систем хөгжүүлэлтийн 1 мэргэжилтэн, нийт 4 мэргэжилтэн шаардагдана.

2.3.1. Мини удирдлагын төвийн тоног төхөөрөмж, серверийн үзүүлэлтүүд

Дараах хүснэгтэд мини удирдлагын төв байгуулахад шаардлагатай тоног төхөөрөмжийн бүрдлийг харуулав:

Хүснэгт 2.2. Мини удирдлагын төвийн тоног төхөөрөмж


№	Нэр	Үзүүлэлт	Тоо ширхэг	Тайлбар
1	Дэлгэц	42 инч Full HD, VGA, HDMI, RS232, USB,	6	Туршилтын 6 өртөөдийг хянах дэлгэц.
2	Сервер компьютер / Dell PowerEdge R740 /	2x Gold 5218, 128G (4x 32G), 12x 600G SAS 15K, H330, 2x 1100W, 2U	1	Нэгдсэн бо-ловсруулалтын системд шаардлагатай суурин компьютер /систем хөгжүүлэгч ИТ инженер ажиллах процессор/
3	График сервер GPX XT242460V4-10GPU	1x Intel R C612 Chipset - Dual 1-Gigabit Ethernet - 4U GPU Server - 2000W (2+2) Redundant Power Supply 1x 2FourteenCore Intel R Xeon® 1x Processor E5-2690 v4 2.60GHz 35MB Cache (135W) 64GB PC4-21300 2666MHz DDR4 ECC LR-DIMM, 10x 7.68TB Intel R SSD D3-S4610 Series 2.5"SATA 6.0Gb/s Solid State Drive, 1x NVIDIA R Quadro R P5000 16.0GB GDDR5X (1xDVI-D, 4xDP), NVIDIA R Tesla™ P100 GPU Computing Accelerator - 16GB HBM2 - PCIe 3.0 x16 - Passive Cooling, LSI MegaRAID 9361-24i SAS 12Gb/s PCIe 3.0 24-Port Controller with 4GB Cache, Mellanox 25-Gigabit Ethernet Adapter ConnectX® -4 Lx EN MCX4111A (1x SFP28), Thinkmate R Server Manager (Datacenter Management Package), Ubuntu Linux 18.04 LTS Server Edition (No Media) (Community Support) (64bit), 3 Year Advanced Parts Replacement Warranty, 4U	1	OCR Камерын хяналтын системд шаардлагатай вагон дугаарыг таниулах сургах зориулалт бүхий график сервер
4	Dell Optiplex 7070 Desktop i7, RX550	9th Generation Intel R Core™ i7-9700 Processor, 8G DDR4 2666MHz, 1T SATA 7.2K 3.5", AMD Radeon RX550 4G Graphic Card (DP/mDP/mDP), Dell KB216 USB Keyboard, Dell MS116 USB Optical Mouse	3	Өгөгдлийн сангийн сервер, Програм хангамжийн сервер Веб сервер,

5	STX-NS XD2422S1- 10G	Intel® C622 Chipset - 10x SATA3 - 2x M.2 - Dual Intel R 10-Gigabit Ethernet (RJ45) - IPMI 2.0 with LAN, 2x Intel R Xeon R Gold 6244 Processor 8-Core 3.6GHz 25MB Cache (150W), 8x 16GB PC4-23400 2933MHz DDR4 ECC RDIMM, Thinkmate R STX-2224 2U Chassis - 24x Hot-Swap 2.5"SATA/SAS3 12Gb/s SAS Single Expander - 1200W Redundant Power, 2x 240GB Intel R SSD D3-S4610 Series 2.5"SATA 6.0Gb/s Solid State Drive, 4x 6.4TB SAS 12.0Gb/s Solid State Drive 2.5" - HGST Ultrastar™ DC SS530 Series (3x DWPD), Broadcom MegaRAID 9480-8i8e SATA/SAS/NVMe 12Gb/s PCIe 3.1 8-Port RAID Controller with 4GB Cache, CacheVault Flash Cache Protection Module for 9460/9480 Series (CVPM05), Intel® 10-Gigabit Ethernet Converged Network Adapter X710-T4 (4x RJ45), Thinkmate R Server Manager (Datacenter Management Package), ThinkNAS™ DirectorProPlus v2.5 - 24-Drive License, ThinkNAS™ DirectorProPlus v2.5 - 24-Drive License, 3 Year Advanced Parts Replacement Warranty	8	Өгөгдлийн сангийн сервер, Програм хангамжийн сервер Веб сервер,
6	DELL S2419H 24"	Дэлгэцийн харьцаа: 16: 9 Дэлгэцийн хэмжээ: 24 Дэлгэцийн төрөл: Full HD Дэлгэцийн нягтаршил: 1920 X 1080 Дэлгэц: LED Дэлгэцийн самбар: IPS Спикер: Тийм	6	Хяналтын мэргэжилтэн хэрэглэх дэлгэц
7	KVM-1716 COMBO-S	17in LCD, Keyboard w/Touchpad, 16port KVM, 1U Rack mount	1	Серверийн ажиллагаанд тохируулга хийх, аюулгүй ажилгаанд хяналт хийх, ашиглах
8	Fortinet FortiGate300D Firewall /Галт хана/	Hardware plus 1 Year 8x5 FortiCare and FortiGuard UTM Protection	1	Серверийн сүлжээний хамгаалалт

9	VGA ур-тасгагч залгуур /3м/		6	Шаардлагатай тоног төхөөрөмж, эд хогшил.
10	DVI ур-тасгагч залгуур /5м/		6	
11	Цахилгааны уртасгагч		8	
12	Ракны олон залгуур		2	
13	Ширээ		3	
14	Сандал		3	
15	Микро дата центр	Available Space -U -29 Width -mm 600 Depth -mm 1400 Height -mm 2000 Weight -kg 374 Input Power Type 230V/ 1P/2P/ 50-60Hz UPS -KVA 6 Mount Type Rack Standard Battery 12V/9AH 16pcs PDU Basic 16Slots Cooling Type Split DX Mount Type Rack CapacitykW 3.9 Monitoring Function Touch Screen Temp.&Hum UPS MgmtCooling Mgmt. Smoke Sensor Leaking Sensor Door Status	2	Энгийн оффист байрлах боломжтой зориулалтын хөргөлт, тог баригч, цэнэг хураагуур бүхий сервер байрлуулах RACK

“В” хэсэг буюу 9 м² талбай бүхий серверийн өрөө:

- 17in LCD, Keyboard w/Touchpad, 16port KVM, 1U Rack mount notebook
- GPU сервер
- Өгөгдлийн сангийн сервер, програм хангамжийн сервер веб сервер, нөөц серверээс бүрдэнэ.



Зураг 2.6. Сервер суурилуулах өрөө (Micro data center)

2.4. Хөрш орнуудын төмөр замын системүүд

- Радио давтамжид суурилан хөдлөх бүрэлдэхүүн тодорхойлох системийн гол тоног төхөөрөмжүүдийн ашиглалтын хугацаа дунджаар 15-20 жил байдаг /физик гэмтэлгүй тохиолдолд/ үйлдвэрээс тогтоогдсон хугацаа 8 жил
- Үнэ хямд
- Харьцангуй олон орны төмөр замын байгууллагууд сонгон хэрэглэж байна. Үүний дотор БНХАУ, ОХУ
- Системийн бүтэц зохион байгуулалт энгийн, хялбар
- RFID түшиглэн дараагийн шатны системүүдийг нэвтрүүлэх, хөгжүүлэх боломжтой

Жишээ нь: БНХАУ-ын 70,000 км төмөр замд 2000 ширхэг TAG¹² уншигч, 800000 вагонд “TAG” суурилуулан “VIS” радио давтамжид суурилсан системийг нэвтрүүлсэн нь төмөр замын ухаалаг системийн үндсэн суурь болж үр ашигтай ажиллаж байна.

Радио давтамжид суурилсан “TAG”-ийг төмөр замын салбарт 1980 оноос Финлянд, Швед, Өмнөд Африк, Герман, АНУ, Энэтхэг зэрэг орнууд ашиглаж эхэлсэн. Төмөр замын менежмент системийг илүү ухаалаг, тээврийн үйл ажиллагааг илүү үр дүнтэй, аюулгүй болгох зорилгоор “RFID” технологийг сонгосон нь чухал үүрэгтэй, найдвартай болох нь туршилтаар багтагдсан.

Төмөр замын салбарт “RFID” технологи нэвтрүүлснээр гарах ашиг тус үр дүнгийн талаар “RFID” insider.com сайт судалгаа хийж дараах дүгнэлтийг гаргасан байна.

Үүнд:

- Хэрэглэгчийн үйлчилгээ сайжирсан
- Вагон илрүүлэлт сайжирсан
- Хэрэглэгчийн сэтгэл ханамж нэмэгдсэн
- Үйл ажиллагааны зардал буурсан
- Хүнээс хамаарсан алдаа буурсан
- Ачаа бараа алдагдах/ хулгайлагдах тоо буурсан
- Логистик саатал буурсан

IoT¹³ дахь “RFID” технологи нь логистикийн салбарт (ялангуяа төмөр зам) өргөн цар хүрээтэй нэвтэрч байгаагаас үзэхэд RFID ашиглалт төмөр замын салбарын зах зээлд 2022 оны эцэс гэхэд 5 тэрбум доллар болж өсөх тооцоо гарчээ.

АНУ, Канадын төмөр зам нь энэ системээр 3,2 сая вагон тоноглож, 20 000 чип уншигч суурилуулсан байна. ОХУ-д зүтгүүрийн 100%, зорчигчийн вагоны 10%, ачааны вагоны 42%, моторт вагоны 89% нь уг төхөөрөмжөөр тоноглогдсон.

RFID системд суурилсан бүтээгдэхүүн нь дэлхийн зах зээл дээр 2000 онд 900 сая доллар, 2005 онд 2650 сая ам.долларын борлуулалттай болсон нь зах зээлд хамгийн хурдацтай өсөж байгаа технологи болж худалдаа, тээвэр, аж үйлдвэрийн салбарт зонхилон ашиглагдаж, тэдгээрийн үйл ажиллагааны процессыг хөнгөвчлөх, бодит цагийн мэдээлэл дээр тулгуурлан оновчтой шийдвэр гаргах, төлөвлөх, ажлыг хялбарчлах болсон. Тус системд үндэслэн дараагийн шатны хөгжүүлэлтийг хийж хөдөлгөөний аюулгүй байдлын системүүд, замын аюулгүй байдлын мэдрэгч тоног төхөөрөмжүүдээр тоноглон нэгдсэн платформ үүсгэн хөгжүүлэн ажиллаж байна. БНХАУ – д галт тэрэгний хөдөлгөөний шууд удирдах систем болох CTCS-3,4 түвшинд хөгжүүлэн хэрэглэж байгаа хэдий ч дээрх технологиудыг

¹² TAG – хөдлөх бүрэлдэхүүнд суурилуулагдах чип

¹³ Internet of everything – юмсын интернет

суурь мэдээлэлд ашиглалалтын ажлын тооцоо, боловсруулалт өгөгдлийн менежментийн хүрээнд тасралтгүй хөгжүүлэн хэрэглэж байна.


Хөрш орнуудын төмөр замын салбарт ашиглаж буй системүүдийн дэлгэрэнгүйг хавсралт 2-т харуулав.

Хүснэгт 2.3. Олон улсын төмөр замын систем

Улс орон	Хяналтын систем (Нэгдсэн хяналтын систем-НХС)	Хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах систем (НХС)	Шууд удирдах систем
БНХАУ	<ul style="list-style-type: none"> Хөдлөх бүрэлдэхүүний хөдөлгөөн хяналтын систем “VIS” БНХАУ-ын төмөр замд /800,000 гаруй ачааны вагонд суурилуулсан/ Төмөр замын вагоны дугаар автоматаар танигч систем 	<ul style="list-style-type: none"> THDS Хэт улаан туяагаар хос дугуйн халалтыг илрүүлэх систем Хос дугуйн холхивчны гэмтлийг акустик аргаар оношлох систем (TADS) Вагоны явах эд ангийн эвдрэл гэмтлийн хөдөлгөөнтэй үеийн зургийг авч илрүүлэх, хянах систем /TFDS/ 	<ul style="list-style-type: none"> Хятад улсын өндөр хурдны төмөр замын галт тэрэгний үйл ажиллагааны хяналтын систем (CTCS-2, CTCS-3)
ОХУ	<ul style="list-style-type: none"> Вагон паркийн нэгдсэн бүртгэл тооллого, вагон хангалтын хяналт, хэрэглээ, зохицуулалтанд дүн шинжилгээ хийх автоматжуулалтын систем /ДИСПАРК/ Чингэлэг тээвэр удирдлагын автоматжуулалтын систем /ДИСКОН/ Мэдээллийн-лавлагааны систем /ДИСКОР/ Хөдлөх бүрэлдэхүүн таних систем ПАЛЬМА /RFID/ 	<ul style="list-style-type: none"> Хөдлөх бүрэлдэхүүний техникийн аюулгүй байдлыг хянах автоматжуулсан хэрэгсэл /КТМС/ 	<ul style="list-style-type: none"> Галт тэрэгний хөдөлгөөний шууд удирдлагын систем СИРДП-Е
БНЭУ	<ul style="list-style-type: none"> Бодит цагийн галт тэрэгний мэдээллийн систем (RTIS) Галт тэрэгний үндэсний лавлагаа Систем (NTES) Мэдээллийн нэгдсэн сан, аюулгүй байдлыг зохицуулах систем 	<ul style="list-style-type: none"> PRS-ийн аюулаас хамгаалах систем Төмөр замын цэрэгжүүлсэн хамгаалалт, аюулгүй байдлын систем (RSHC) 	<ul style="list-style-type: none"> Галт тэрэгний хөдөлгөөний нэгдсэн удирдлагын систем (CTC)

2.5. Хөдлөх бүрэлдэхүүний хөдөлгөөн хяналтын тоног төхөөрөмжийн шийдэл

Төслийн хүрээнд хяналтын шийдэл үндсэн 2 төрлийн технологийг нэвтрүүлэх бөгөөд үүнд “VIS” хөдлөх бүрэлдэхүүн тодорхойлох радио давтамжид суурилсан систем дотоодын вагон хяналтад тохиормжтой, “OCR” тэмдэгт таних камерийн хяналтын систем энэ нь транзит вагон хянах, тодорхойлоход илүү давуу талтай.



Зураг 2.7. Хөдлөх бүрэлдэхүүний хөдөлгөөнийг хянах “VIS” болон “OCR” системүүд

2.5.1. “VIS” Хөдлөх бүрэлдэхүүн тодорхойлох систем

2.5.1.1. Системийн тойм

VIS систем нь хөдлөх бүрэлдэхүүнд суурилуулсан “TAG”-д програмчилсан өгөдлийг радио давтамжийн технологи ашиглан өгөдлийн менежментийн төврүү илгээдэг. Вагоны дугаар болон бусад суурь мэдээллийг “TAG”-д ямар нэгэн физик холбоо болон утасгүйгээр програмчлан оруулдаг. ‘TAG’ нь /passive/ тэжээлийн эх үүсвэргүй бөгөөд үүн дээрх өгөгдлийг дахин програмчлах боломжтой.

TAG-д туссан богино долгионы давтамжийн дохиог RF модулаар дамжуулан RF antenna¹⁴ дамжуулагч хүлээж авч боловсруулдаг. Радио давтамжийн модулаас илгээсэн дохиог уншигч карт болон нэгдсэн боловсруулалтын системийн тусламжтай галт тэрэгний вагоны тайлан мэдээ болгодог.

Хөдлөх бүрэлдэхүүн тодорхойлох систем нь хэрэглэгчийг бодит цагийн мэдээллээр хангах бөгөөд бүрэн автоматжуулалтад суурилан вагон байршил болон тэдгээрийн ашиглалтын нөхцөлийг тодорхойлох боломжтой болно.

Тиймээс “VIS” нь вагон удирдлагын амин чухал систем юм. Тус систем дэлхийн ихэнх төмөр замын сүлжээнд тоноглогдсон бөгөөд тээврийн менежмент, хяналтыг сайжруулах, үр ашгийг дээшлүүлэх үр дүнтэй дэд бүтцэд тооцогдож байна.

¹⁴ Radio frequency antenna- Радио давтамж дамжуулагч

1990-ээд оны сүүл үеэс хойш “НТК¹⁵- Харбины төмөр замын судалгааны институт” нь БНХАУ-ын төмөр замд 800,000 вагон дээр тээврийн “TAG” суурилуулж, 3000 гаруй уншигчийг төмөр замын гол шугам, өртөөдүүдэд нэвтрүүлсэн.

Нэмж дурдахад “НТК” нь үйлчлүүлэгчдэд вагоны мэдээллийн эрэлт хэрэгцээг хангах зорилгоор VIS өгөгдлийн менежмент болон лавлагааны системийг боловсруулж, хөгжүүлсэн.

2.5.1.2. Системийн тохируулга

Системийн иж бүрдэл:

- TransCore-ийн AT5118 тээврийн TAG /хөдлөх бүрэлдэхүүнд суурилуулах/
- Зам дээрх уншигч байгууламжийн тоног төхөөрөмж
- Өгөгдлийн удирдлага ба мэдээлэл авах төв ба терминалууд

AT5118 TAG-д утасгүй сүлжээ /wireless/ ашиглан өгөгдлийг оруулдаг. Энэ нь цаг агаарын эрс тэс уур амьсгалд, цахилгааны эх үүсвэр шаардахгүйгээр идэвхгүй /passive/ байдлаар ажилладаг.



Зураг 2.8. Тээврийн чип “AT5118 TAG” ба AP4600 програмчлагч

Галт тэрэгний суурь өгөгдлийн мэдээллийг TransCore¹⁶-ийн AP4600 олон үйлдэлт програмчлагч ашиглан TAG-ийг програмчлан ашиглалтад оруулна. Вагоны мэдээллийг TAG-д хадгалахыг дараах байдлаар санал болгож байна.

Хүснэгт 2.4. 128 бит нэг вагоны суурь өгөгдөл, “TAG”-д програмчлах мэдээлэл

Өгөгдлийн тодорхойлолт	Бит	Санал болгож буй формат
Вагон эзэмшигч	6	“T” means MR; “Q” хувийн эзэмшигч.
Вагон ангилал	6	“A Z”
Вагон төрөл	10	5 бит цифр эсвэл тэмдэгт
Вагон дугаар	22	7-8 бит цифр
Вагон урт	12	
Вагоны үйлдвэрлэсэн газар	6	“A.....Я”
Вагон үйлдвэрлэсэн он, сар	18	
Баталгаажуулалт	12	
Арлын дугаар	12	


¹⁵ Harbin Railway Institute of Science & Technology – БНХАУ, Харбины төмөр замын судалгааны институт;

¹⁶ Transcore- АНУ-д төвтэй төмөр замын технологи хөгжүүлэлтийн компани

Вагон савны жин	8	
Вагон даац	8	
Вагон эзэлхүүн	8	




Зураг 2.9. “TAG” бэхэлгээ



Зураг 2.10. “TAG”-ийг вагонд суурилуулсан байдал ард талаас

Looking at wagon lateral




Зураг 2.11. “TAG”-ийг вагонд суурилуулсан байдал хажуу талаас

TAG нь төмөр хаалтанд бэхлэгдэж, хаалт нь вагонуудын доод аралд суурилуулагдана. AT5118 тээврийн TAG, AP4600 олон үйлдэлт програмчлагч аль аль нь АНУ-ын TransCore компанийн бүтээгдэхүүнүүд юм. Бүтээгдэхүүний профайлыг энэ баримт бичгийн хавсралт 1 ба хавсралт 2-т хавсаргасан болно.

Уншигч хэсэг дараах тоног төхөөрөмжүүдээс бүрдэнэ.

- RF дамжуулагч

- Гол тоологч 4 ширхэг
- А RFID уншигч : RF модулиуд, уншигчийн карт ба өгөгдөл боловсруулах процессор;
- Эрчим хүчний эх үүсвэрүүд / хувьсах хүчдэл байхгүй тохиолдолд нарны эх үүсвэр байж болно/
- Өгөгдөл дамжуулагч сүлжээ.



Зураг 2.12. VIS систем дэх тоног төхөөрөмжүүдийн бүтэц зохион байгуулалт

RF дамжуулагч: “НТК”-ын RF дамжуулагч нь хаалтанд бэхлэгдэх бөгөөд хаалт нь зам төмөр хооронд хоёр зэргэлдээ дэрийн дунд суурилагдсан байна. TAG-д хадгалагдсан өгөгдлийг радио давтамжийн бичил долгионы тусламжтайгаар хүлээж авна. Дамжуулагч нь RFID уншигч нэгжтэй коаксиаль кабелиар холбогдоно.




Зураг 2.13. НТК RF дамжуулагч



Зураг 2.14. RF дамжуулагчийн техникийн үзүүлэлтүүд

Гол тоологч: RFID уншигч хэсэг бүр дөрвөн ширхэг дугуй мэдрэгчээс бүрдэнэ /гол тоологчоос/. Гол тоологч нь пааландсан утастай тогтмол соронзон ороомог бөгөөд эпоксид капсултай байдаг. Эрчим хүчний эх үүсвэргүйгээр идэвхгүй байдлаар ажилладаг. Уншигч хэсгийн дамжуулагчаас 50 м зайд суурилуулсан 2 ширхэг гадна мэдрэгч нь тэгш сондгой чиглэлд галт тэрэг байгаа эсэхийг илрүүлж дараа нь ажиллах горимд шилжинэ. Дотор хоёр мэдрэгч нь RF-ийн дамжуулалтыг хянаж, вагоны голын тоо, хөдлөх бүрэлдэхүүний хурдыг илрүүлнэ. Голын зайг мэдээллийн бааз дахь мэдэгдэж буй дугуйны тэнхлэгийн зайтай харьцуулах замаар зүтгүүр, вагоныг тодорхойлоход ашиглана.



Зураг 2.15. Гол тоологч

Гол тоологчийн техникийн үзүүлэлтүүд дараах байдалтай байна.

- эрчим хүчний эх үүсвэргүй ажиллах, идэвхгүй хэлбэртэй
- эсэргүүцэл: $\geq 100M\Omega$ 20~25°C; 1000V ; 80% харьцангуй чийгшил
- статик дуу чимээ: 10 мВ;
- галт тэрэгний хамгийн бага хурд 33 км/ц
- тохируулга ± 5 mm
- дохиолол дуу чимээний харьцаа 10 дБ

Уншигч нэгж “НТК” нь төмөр замын нөхцөлд “RFID” гурван төрлийн уншигч хэрэглэж байна.

- НТК-07С RFID уншигчийг гол замын дагуу суурилуулна.
- НТК-AEI-DL1 RFID уншигч нь салбар зам, өртөө зөрлөгийн болон депогийн замууд, ялгах өртөөний замууд дээр суурилуулах боломжтой
- НТК-AEI-W1 RFID уншигч загварыг өртөө, депогийн , орох гарах хэсэгт суурилуулна.

НТК-07С Уншигч


- НТК-07С уншигч төхөөрөмж нь гол замын дагуу, өртөөдийн орох, гарах хэсэгт суурилуулах зориулалттай. Уншигч нэгж нь дараахь онцлогтой.
- 120 км/цаг хүртэл хурдтай галт тэрэг;
- TAG өгөгдлийг өндөр нарийвчлалтай унших;
- (Server rack¹⁷) дотор 2U буюу 8.89 см өндөр хэмжээтэй RF модуль, уншигч, DSP¹⁸ тоон дохио боловсруулалтийн процессорыг хамтад нь багтаасан дизайнтай;
- Зам дээрх байгууламжид аянга зайлуулагч, цахилгаан тэжээл, өгөгдөл дамжуулах нэгжүүд багтсан бага зардлаар хялбар суурилуулагдах хяналтын хайрцаг.



Зураг 2.16. НТК-07С уншигч нэгж

¹⁷ Server rack – серверийн тавиур,


¹⁸ digital signal processing - тоон дохио боловсруулалт



Зураг 2.17. НТК-07С уншигч хэсэг

НТК-AEI-DL1 Уншигч нэгж НТК-AEI-DL1 Уншигч төхөөрөмж нь дов, өртөөд болон депогийн замуудад суурилуулахаар загварчлагдсан. Нэг DL1 уншигч нэгж нь хамгийн ихдээ 12 зам дээр суурилуулагдах дамжуулагч, дугуй мэдрэгчтэй /гол тоологчийг/ нэгтгэн ажиллах боломжтой.

Хэд хэдэн дамжуулагч болон гол тоологчууд



Зураг 2.18. НТК-AEI-DL1 уншигч нэгж нь хэд хэдэн дамжуулагч болон гол тоологчуудыг нэгтгэн ажилладаг

Уншигчийн нэгж нь дараах онцлогтой:

- 80 км/ц хүртэл хурдтай галт тэрэг
- TAG-ны өгөгдлийг өндөр нарийвчлалтай унших;
- RF модуль, уншигчийн карт, өгөгдлийн процессор бүхий дизайнчлал;
- Зам дээрх байгууламжид аянга зайлуулагч, цахилгаан тэжээл, өгөгдөл дамжуулах нэгжүүд багтсан бага зардлаар хялбар суурилуулагдах хяналтын хайрцаг;



Зураг 2.19. НТК-AEI-DL1 Уншигч нэгж



Зураг 2.20. НТК-AEI-DL1 Уншигч хэсэг

НТК-AEI-W1 Уншигч нэгж: W1 уншигч нь өртөө, депогийн орох гарах дохион дээр суурилуулах зориулалттай. Эдгээр газруудад галт тэрэг найруулах, зогсох, эргэх боломжтой байдаг. W1 нь галт тэрэгний жигд бус хөдөлгөөнийг зохицуулахад зориулагдсан.


Онцлог шинж чанарууд:

- 80 км/ц хүртэл хурдтай галт тэрэг;
- TAG-ны өгөгдлийг өндөр нарийвчлалтай унших;
- RF модуль, уншигчийн карт, өгөгдлийн процессор бүхий дизайнчлал;
- Зам дээрх байгууламжид аянга зайлуулагч, цахилгаан тэжээл, өгөгдөл дамжуулах нэгжүүд багтсан бага зардлаар хялбар суурилуулагдах хяналтын хайрцаг;



Зураг 2.21. НТК-AEI-W1 Уншигч нэгж


Уншигчийн хэсгийн бүтэц зохион байгуулалтыг зураг 2.24-д харуулав.



Зураг 2.22. HTK-AEI-W1 Уншигч хэсэг

2.5.1.3. Өгөгдлийн менежмент ба мэдээлэл авах терминалууд

VIS мэдээллийн менежмент ба мэдээлэл авах терминалууд нь ихэвчлэн CTC¹⁹, өртөөд болон депо дээр суурилуулагддаг. Доорх зурагт “VIS”-ийн сүлжээг харуулав.



Зураг 2.23. HTK VIS Мэдээллийн удирдлага ба лавлагааны терминал, сүлжээний тохируулга

¹⁹ Centralized traffic control center – Нэгдсэн удирдлагын төв

НТК-ын “VIS” нь харилцаа холбооны сүлжээний янз бүрийн арга замыг дэмжиж байгаа хэдий ч өгөгдлийн менежментийн сүлжээ болон мэдээллийн терминалуудын тохиргоо нь дотоодын сүлжээний дэд бүтцийн тоноглолоос хамаарна. Ер нь НТК-ын “VIS” нь шилэн кабель, MODEM ба GPRS бүхий зориулалтын утасны шугамаар мэдээлэл дамжуулалтыг дэмждэг

2.5.1.4 Системийн ажиллагаа

2.5.1.4.1 Зам чөлөөтэй үед систем идэвхгүй байх:

Уншигч хэсгээр галт тэрэг өнгөрөөгүй тохиолдолд уншигч нэгж /хяналтын хайрцаг/ цаг тутам CPS²⁰-тэй холбоо тогтоож байдаг. “CPS” нь уншигчруу мэдээллийн асуулга илгээх бөгөөд уншигч нь үүнд хариулдаг. Гэхдээ галт тэрэг өнгөрч байгаа тохиолдолд уншигчид “TAG”-ыг уншиж, асуулгад хариу өгөхгүй.

2.5.1.4.2 Галт тэрэг уншигч хэсгээр ойртох үед систем бэлэн байдлын горимд шилжих:

Галт тэрэг ойртох үед гаднах мэдрэгч /гол тоологч/ ажилладаг. Системд гол тоологчоос дохио ирэхэд хувьсагч ба параметрийг тохируулах, “RF” дамжуулагчийн богино долгионы дохио, RF модулийг идэвхжүүлж эхлэх бэлэн байдалд шилждэг.

2.5.1.4.3 Галт тэрэг уншигч хэсгийг дайран өнгөрөх үед систем бэлэн байдалд ажиллах:

Вагон нь RF-ийн антены ажлын хүрээнд шилжих үед “TAG”-ийн өгөгдлүүд дамжуулагчруу илгээгдэнэ. RF дамжуулагч модуляцлагдсан “TAG” өгөгдлийг уншигчийн нэгж дэхь RF-ийн модуль руу илгээдэг. Демодуляцлагдсан өгөгдлийг вагоны дугаар үүсгэх, мэдээллийг хадгалах зорилгоор уншигч карт, процессор руу илгээнэ.

2.5.1.4.4 Гол тоологч, вагон тоолох, хурд тодорхойлох:

“TAG”-ийн өгөгдлийг унших үед систем мөн вагон тоо, голын тоо, хурдыг тодорхойлдог. Систем галт тэргийг бүрэн уншиж дууссаны дараа RF модуль идэвхгүй горимд шилжинэ.

2.5.1.4.5 Вагон дугаарыг CPS рүү илгээх:

Систем нь “TAG” болон галт тэрэгний мэдээллийг нэгтгэн вагоны бүх дугаарыг багтаасан галт тэрэгний файлыг үүсгэж CPS-г илгээнэ.

2.5.1.5 Системийн үзүүлэлтүүд

Хүснэгт 2.5. “VIS” системийн техникийн үзүүлэлтүүд

Галт тэрэгний хурд:	350 км/ц НТК-07С хувилбар
	80 км/ц НТК-AEI-DL1 ба -W1 хувилбар
Уншигч нэгжийн эрчим хүчний хэрэглээ:	≤30W for 07C хувилбар
	≤30W for W1 хувилбар
	≤45W for DL1 хувилбар
Радио давтамжийн хүрээ:	902МГц ~ 928МГц
Радио гаралтын хүч:	0.5W ~ 1.6W
TAG-ны өгөгдөл коодлох:	FSK
Радио давтамжийн хэлбэлзэл:	Within ±0.0005%
Гармоник хэлбэлзлийн гаралт:	≤50
Дамжуулагчийн өргөн:	5KHz

²⁰ Centralized processing system- Нэгдсэн боловсруулалтын систем;

Дамжуулагчийн эсэргүүцэл:	50Ω	
Дамжуулагчийн өсгөлт:	8.6 ~ 9.6	
Тогтмол хүчдэлийн коэффициент:	≤ 1.5	
Бичил долгионы цацрагийн хүрээ:		120° (зам дагуу); 45° (босоо)
Дугуй мэдрэгч:		$V \geq 0.75V$
Дугуй мэдрэгчийн эсэргүүцэл:		$\geq 100M\Omega$ (20 ~ 5°C; 1000V ; 80% харьцангуй чийгшил)
Статик дуу чимээ V_p -р:		≤10милливольт
Чичиргээний дуу чимээ V_p -р:		≤100милливольт
Системийн эрчим хүч хангалт:		AC220V (-20% +15%), 50 Гц
Системийн дундаж алдаа (MTBF)		$\geq 10^4$ цаг механик эд ангиудад
Системийн засвар хийх хугацаа (MTTR)		$\geq 10^5$ цагт цахилгааны эд ангиудад
		≤10 минут механик эд ангиудад
		≤3 минут цахилгааны хэсгүүдэд
		Системийн ашиглалтын хугацаа 8 жил

Хүснэгт 2.6. “VIS” төхөөрөмжийн ажиллах орчин

Өгөгдлийн тодорхойлолт	-25°C ~ +70°C	
Тоног төхөөрөмжийн ажиллах температур	-40°C ~ +70°C	
Зам дээрх байгууламж тоног төхөөрөмжийн ажиллах температур		<95% RH under ambient of

Өгөгдөл дамжуулах: VIS уншигч нэгж нь CPS-ийн дээд сервер рүү өгөгдөл дамжуулах гурван аргыг дэмждэг.

- Орон нутгийн онцлогоос хамааран шилэн кабель эсвэл интернэт сүлжээ;
- Орон нутгийн онцлогоос хамаарч утас ба MODEM;
- Орон нутгийн нөхцөл байдлаас шалтгаалан GPRS.

2.5.1.6. “НТК”-ын “VIS” суурилуулалт ба газар шорооны ажил:

2.5.1.6.1 RFID уншигч хэсэгт суурилуулах:

- ✓ НТК-AEI-DL1- RFID уншигч төхөөрөмжийг салбар замууд, өртөөдийн хажуугийн замуудад;
- ✓ НТК-AEI-W1 RFID уншигчийг өртөөд эсвэл дов, депогийн зам дээр суурилуулна;

Дамжуулагч суурилуулах цэгийг сонгохдоо дараах нөхцөлийг анхаарна:

- Аль болох шулуун замтай хэсэг газрыг сонгох хэрэгтэй, хэрэв энэ шаардлага хангагдахгүй бол муруйн радиус нь 1000 метрээс бага байж болохгүй.
- Дамжуулагч суурилуулахдаа сонгох байршил нь аль болох хянах хайрцагтай ойр байх шаардлагатай. Дамжуулагч болон хянах хайрцгийг холбосон хос кабелийн урт 30м-ээс бага байх ёстой.
- Дамжуулагч суурилуулах газрыг сонгохдоо зам төмрийн голд байрлуулна, хэрэв ямар нэг шалтгааны улмаас зам төмрийн дунд суурилуулах боломжгүй бол хамгийн ойрын зам төмрийн залгааны хэсгээс 10м-ээс их зайд суурилуулах хэрэгтэй.


Гол тоологчийг идэвхижүүлэгч, хөдлөх бүрэлдэхүүн нэвтрэх үеийн дугуй мэдрэгч болон гарах үеийн дугуй мэдрэгчийг суурилуулах цэгийг сонгохдоо анхаарах зүйл:

- Дугуйн мэдрэгчийг суурилуулах цэг нь галт тэрэгний явж байгаа чиглэлд нийцүүлэн дамжуулагч антенны урд байрлуулна. Өөрөөр хэлбэр галт тэрэг эхлээд дугуй мэдрэгчээр

дамжуулан дараа нь дамжуулагч антенаар дамждаг бөгөөд хөдлөх бүрэлдэхүүн нэвтрэх үеийн дугуй мэдрэгч болон гарах үеийн дугуй мэдрэгчийн төв шугам нь дамжуулагчийн төв шугамаас 1000мм – 1500мм байх шаардлагатай. Хоёр чиглэлтэй зам дээр дугуй мэдрэгчийг антенийн хойно урд аль ч талд нь суурилуулж болно.

- Ашиггүй байрлалд суурилуулахаас зайлсхийх хэрэгтэй, төхөөрөмж аянга зайлуулагчтай байх, үерийн уснаас хамгаалагдсан байх, хөрсний нуралтаас хамгаалагдсан байх гэх мэт байгалийн гамшигийн үед бат бэх байх шаардлагатай.
- Дугуй мэдрэгчийг идэвхижүүлэгчийг дамжуулагчаас 40-50м зайд суурилуулах.

2.5.1.6.2 Суурилуулах арга:



Зураг 2.24. Өртөөний гол замд уншигч нэгж суурилуулах явц.

2.5.1.6.3 RF Дамжуулагч суурилуулах

Дамжуулагчийг төмөр замын дэр модны дунд хавчиж суурилуулах ба хоёр талын зай нь тэнцүү мөн нэг түвшинд байх хэрэгтэй.



Дамжуулагч суурилуулах ажиллагаа:

1. Дэр модны доод хэсгийг хөндийлөөд тэр хэсэгтээ сувгийн ган суурийг байршуулна.
2. Дээд доод 2 дэр мод хавчигч болон үзүүр нь тус бүрдээ 3 ширхэг резинэн чичирхийлэл бууруулагчтай дамжуулагчийн суурийг байршуулна, тохиромжтой байдлаар тавина (нүх

томтой хавчигчийг хяналтын хайрцагны хажуу талд байрлуулна) үүний дараа 4 боолтоор чангалан бэхэлнэ. Шууд 4 хананд нь хавчигчаа бэхлэн боолтоор чангалаад бэхэлнэ.



- 3 Дамжуулагчид дагалдаж ирдэг давхар кабелийг хяналтын кабинруу ордог кабелтай холбоод өндөр даралтын хамгаалалтын хоолой руу оруулна, түүнчлэн өндөр даралттай хоолойг дамжуулагчийн арын хэсэгт нягт холбоно.



- 4 Дамжуулагчийг зориулалтын суурин дээр сайн бэхэлж чангална. Доор зургийг үзүүлэв.



- 5 Дамжуулагчийн дээд талд хамгаалах халхавчийг байрлуулан сайн бэхэлж чангална.
- 6 Өндөр даралтын хоолойны үзүүр нь хянах хайрцагтай холбогдон суурилуулалтын ажил дуусна.



Анхаарах зүйлс: Дамжуулагчийг суурилуулах үед 6 чичиргээ бууруулагчийг дамжуулагчийг нүхэнд бэхлэн, суурилуулсны дараа 6 ширхэг чичиргээ бууруулагч ямар нэг даралтын хүчийг хүлээн авах ёсгүй.

2.5.6.1.4. Дугуй мэдрэгч суурилуулах /Гол тоологч/

1. Төлөвлөгдсөн цэг дээр дугуй мэдрэгчийг суурилуулна. Дугуй мэдрэгчийг зам төмөр дээр хавчсан хэлбэрээр байрлуулан төмөр замын дотор талд суурилуулна.
2. Дугуй мэдрэгчийн шугам (өөрийн байгаа кабелийн утас хангалтгүй бол ижил утсыг нэмж залган ашиглах боломжтой) хоолойгоор дамжин орсон кабель хянах хайрцагны хүлээн авагчийн портонд холбогдоно.
3. Дугуй мэдрэгчийн кабель энгийн хамгаалалттай кабел ашиглагдсан байвал заавал ган хоолой эсвэл кабель хамгаалах тусгай хамгаалалт ашиглан ёстой, зам төмрийн доогуур гарсан кабелийг хэсгийг зориулалтын хоолойгоор хамгаална.

Анхаарах зүйл: Дугуй мэдрэгчийг суурилуулахдаа зам төмрийн толгойн төвшнөөс 35 ~ 40 мм доогуур байх ёстой. Галт тэрэгний хурд өндөр тохиолдолд хоорондын зайг тогтоосон хэмжээнээс илүү хол суурилуулж болно.

2.5.6.1.5 Уншигч хайрцаг дахь кабелийн холболт

1. Дугуй мэдрэгч нь коксиаль кабелиар уншигч хайрцагтай холбогддог.
2. Галт тэрэгний хос дугуйн даралтыг мэдрэх дараалал нь #1、#2、#3、#4 үед галт тэрэгний явах чиглэл нь тэгш;
3. Галт тэрэгний даралт өгөх дараалал нь #4、#3、#2、#1 үед галт тэрэгний явах чиглэл нь сондгой;

Төхөөрөмжийг тохируулж турших:

1. RF дамжуулагч, дугуй мэдрэгч хоёрыг заавал хооронд нь холбох ёстой. Дугуй мэдрэгч, “TAG” дахь вагоны өгөгдлийн мэдээлэлүүдийг тус бүрд нь RS-232-2 цуваа интерфэйсээр дамжуулан хост CPS²¹ серверрүү илгээдэг.
2. CPS сервер болон AEI төхөөрөмж нь RS-232-2 протоколын дагуу мэдээлэл солилцдог, дохионы түвшин нь 9600bps байна.
3. Хост компьютерийн CPS програм хангамжийг идэвхижүүлэхэд 2RX, 2TX дохио ээлжлэн анивчдаг. Галт тэрэг уншигч төхөөрөмжийг дайран өнгрөхөд дугуй мэдрэгчийн гэрэл асна, RF

²¹ Centralized processing system- Нэгдсэн боловсруулалтын систем

дамжуулагч бас асна, “TAG”-ны мэдээлэл дамжуулагчруу илгээгдэхэд уншигч хайрцаг дахь процессорын гэрэл анивчдаг.

2.5.1.7 Тоног төхөөрөмж суурилуулах хугацаа

Хүснэгт 2.7. VIS системийг суурилуулах хугацаа

Бүтээгдэхүүн	Тээвэрлэлт	Суурилуулалтын хугацаа	НТК инженерүүд
НТК-07C RFID уншигч	10 долоо хоног	2 өдөр	3
AEI-DL1 RFID уншигч	10 долоо хоног	2-10 өдөр	3
AEI-W1 RFID уншигч	10 долоо хоног	2 өдөр	3
“CPS”-г өртөөдөд суурилуулах	10 долоо хоног	1 өдөр	3
СТС менежмент ба мэдээллийн лавлагааны төв/ Management and Polling Center /	10 долоо хоног	7 өдөр	4

2.5.2. OCR²² Camera хяналтын систем

Тэмдэгт таних камерийн хяналтын систем нь вагоны дугаарыг “AI” технологийн тусламжтай таних үйл явц бөгөөд уг таньсан дугаарыг өгөгдөл боловсруулах төврүү илгээнэ. Төмөр замын өртөөд, логистикийн төв, далайн боомт, үйлдвэрүүдэд уг тусгай зориулалтын камерын хяналтын системээр тоноглодог. Төслийн хүрээнд хилийн өртөөдөд транзит вагон хянахад тохиромжтой гэж үзэж байна.

Камерийн хяналтын шийдлийн шинж чанар:

- Вагон, UIC²³-аас олгосон вагон дугаарууд таних чадвар;
- Хөдлөх бүрэлдэхүүний чиглэл тодорхойлох;
- Дээрээс болон доороос, хажуу талаас бичигдэж авсан дүрс зурган баримтжуулалт;
- Хаалга нээхийн онгойсон болон эвдрэл гэмтэл гарахад өгөх дохиоллын систем;
- Аюултай бараа, бусад төрлийн шошго тэмдэгийг таних;
- Вагоны гол тоолох, тодорхойлох;

Тоног төхөөрөмжийн бүрдэл хэсгүүд:

- ✓ Гадаа байрлах камер, халаагчтай;
- ✓ LED гэрэлтүүлэг;
- ✓ Цахилгааны хайрцаг;
- ✓ Гол тоологч;
- ✓ Видео серверүүд;
- ✓ Програм хангамж;

Камер болон LED гэрэл цаг агаарын хүчин зүйлээс хамгаалагдсан. Камерууд нь хяналтын баганан дээр суурилуулагдаж, интернет сүлжээгээр системд холбогддог. Бүрэн суурилуулалт нь дулааны болон цахилгаан соронзон нөлөөллийн эсрэг хамгаалагдсан.

Техникийн тодорхойлолт:

- Танилт, илрүүлэлтийн хувь хэмжээ 95% иас багагүй;

²²Optical character recognition camera system – Тэмдэгт таних, тодорхойлох камерийн хяналтын системд;

²³International Union of Railway - Олон улсын төмөр замын холбоо;


- Бичлэгийн дүржүүлэх хурд 95 фрейм/сек ;
- Ажиллах температурын хязгаар -40 - +60°C-д;
- Хяналтын бүс 5 – 10 метр өргөн;
- Гэрэлтүүлэг - 100 люмениэс их;
- Хоёр чиглэлд танилт хийнэ;
- Техникийн дохиоллын хуваарьтай;
- Үндсэн үйл ажиллагааны үр дүн;
- Хурд, чиглэл, голын тоог тодорхойлох;
- Галт тэрэг өнгөрөхөд өдөр шөнийн видео бичлэг;
- Галт тэрэгний дугаар илрүүлэх;
- Аюултай ачааны тэмдэг тэмдэглэгээг таних;
- Зураг танилт;
- Шүүлтүүрийн функц (хяналтын цифр, геометр дүрс таних);
- Програм хангамжийн интерфэйсүүд сервертэй холбогддог;
- Хөдөлгөөн зохицуулах төвийн хяналтын системтэй нэгтгэх;



Зураг 2.25. OCR камерын системийг хэрэглэдэг улс орнууд

Тус камер нь аль ч улиралд цаг агаарын хүчин зүйлийн нөлөөнд өртөхгүй -40, +50°C-д байнга ажиллахаар үйлдвэрлэгдсэн.

- Гол тоолох;
- Чиглэл тодорхойлох;
- Вагон бүрийн хурд тодорхойлох;



Зураг 2.26. Гол тоологч

Гаднах хяналтын самбарын өгөгдөл:

- Хэмжээсүүд: 940 x 700 x 420 мм
- Жин: 12 кг
- Температур: - 40°C
- Чадлын зарцуулалт: 1 килоВаттаас ихгүй

Сүлжээний холболт


- Самбарын бүх төхөөрөмжүүд -40°C-д ажиллана;
- Самбар 230 Вольт хувьсах гүйдлээр ажиллана.




Зураг 2.27. OCR системийн тэжээлийн самбар

Програм хангамжын ажиллах орчин

- Мэдээллийн сүлжээний логиктойгоор дугаар таних процесс.
- Вагоны арал болон кузовын дугаар таних.
- Дугаар таних найдваржилт сайн
- Тусгай тэмдэг тэмдэглэгээ, тоо зэргийг нэг бүрчлэн шалгадаг.
- Нарийвчлалтай геометр дүрс шүүлтүүртэй
- Камерын авсан дүрс зургуудыг харьцуулж хамгийн сайн танигдсаныг сонгодог.



Зураг 2.28. OCR (Оптик тэмдэгт, үсэг) дугаар танилт



Зураг 2.29. “OCR” камер өдөр шөнийн горим

2.5.3 “Шилэн кабель” онолын хэсгийн товч танилцуулга:


Шилэн кабель нь мэдээллийг бүрэн бүтэн, хурдан шуурхай дамжуулах хэрэгсэл юм. Шилэн кабелийн цахилгаан холбооноос ялгагдах гол онцлог нь мэдээлэл дамжуулахдаа цахилгаан дохио биш, гэрлийн дохиог ашигладаг.

Оптик холбоог уламжлалт цахилгаан ба радио холбоотой харьцуулахад нэвтрүүлэх давтамжийн зурвас өргөн, өгөгдөл алдагдал бага, гадны цахилгаан соронзон нөлөөлөл багатай, мэдээллийн аюулгүй байдал, дохионы нууцлал, хамгаалалт сайн уян хатан зэрэг давуу талтай.

Шилэн кабелийн 1013-1016 Гц-ийн давтамжийн зурвас нь металл кабелийн системийн давтамжийн зурвасаас (коаксиаль кабелийн 500MHz) их байх ба миллиметрийн радио системээс ч (сүүлийн үед миллиметрийн радиосистемийн модуляцийн зурвас 700MHz хүрч байна) хэд дахин их юм. Одоогийн байдлаар шилэн кабелийн давтамжийн зурвас бүрэн ашиглагдаж чадаагүй байна. Харин 100 км зайд хэдэн Гц-ийн, 300 км зайд 100 ГГц-д модуляцлагдсан дохиог завсрын өсгөлтгүй дамжуулах боломжтой.

Шилэн кабелийн давтамжийн зурвасыг цааш өргөсгөж болно. Тухайлбал хэд хэдэн гэрлийн дохиог өөр хоорондоо ялгаатай долгионы урт дээр кабелийн нэг шөрмөсөөр зэрэг дамжуулах замаар шилэн кабелийн давтамжийн зурвасыг улам өргөтгөж болно. Үүнийг долгионы уртын нягтруулгын технологи (WDM) гэж нэрлэнэ.

Өгөгдөл дамжуулалтын алдагдлын туршилт 1960 оноос эхлэн хийгдсэн. Анхны туршилтаар шилэн кабелийн нэг километр дахь унтралт 1000 дб байсан. Судлаачдын сүүлийн үеийн туршилтын үр дүнд 0.2-0.5 дб хүртэл бууруулж, дамжуулагчдын хоорондох зайг 90-120 км хүртэл уртасгаж чадсан байна. Шилэн кабель нь анх 1000 дб/км унтралттай байсан бол одоо 1550 нм долгионы уртад 0.2 дб/км унтралт үзүүлэх болсон. Энэ нь оптик холбооны хамгийн гол давуу тал юм.



Зураг 2.30. Оптик холбооны үндсэн 4 хэсэг


Цахилгаан тусгаарлалт, аюулгүй байдал: Оптик шилэн кабель нь шил буюу хуванцар цахилгаан тусгаарлагчаар хийгддэг учраас металл кабель шиг газардуулга, интерфэйсийн, шуугианы нөлөөлөл байхгүй. Энэ шинж чанараараа оптик кабель нь цахилгааны туйлшрал ихтэй орчинд ямар ч алдагдалгүй мэдээлэл дамжуулах бүрэн боломжтой.

Дохионы нууцлал: Шилэн кабелиар дамжиж байгаа гэрэл их хэмжээгээр сарнидаггүй учир дохионы нууцлал маш өндөр. Зэс кабельтай харьцуулахад гэрлийн дохиогоор дамжуулсан өгөгдлийг шилэн кабелиас зориулалтын бус аргаар сэргээж авах боломжгүй. Оптик холбоог дамжуулалтын нууцлал шаардлагатай цэргийн байгууллага, банк зэрэг байгууллагын өгөгдлийн сүлжээнд хэрэглэхэд давуу талтай.


Шилэн кабелийн бүтэц: Optic fiber буюу шилэн утас нь өөрийн уртын дагуу гэрлийг дамжуулдаг шил эсвэл хуванцар утас юм. Шилэн кабель нь бусад холбооны хэрэгслүүдээс хол зайд гэрлийн хурдаар мэдээллийг дамжуулдаг учир харилцаа холбоонд голчлон хэрэглэгдэж байна. Металл утасны оронд шилийг хэрэглэснээр дамжиж байгаа дохио нь алдагдал (өөрөөр хэлбэл эсэргүүцэл багатай) багатайгаар дамжихын зэрэгцээ цахилгаан соронзон нөлөөлөлд ордоггүй. Шилэн утас нь гэрэлтүүлэг, зургийг бага зайд тусган гаргах, мэдрэгчүүд болон шилэн лазер хэрэглэгддэг байна.

Олон тусгалт, олон замтай шилэн кабелийг Multi-mode fiber буюу Олон төлөвт кабель, дан ганц дохио дамжуулах чадвартайг нь Single-mode fiber буюу Дан төлөвт кабель гэж нэрлэдэг. Олон төлөвт кабелийг богино зайд, маш өндөр хүчин чадал шаардаж байгаа үед хэрэглэдэг. Дан төлөвт кабелийг голдуу хол зайд буюу 550 метрээс хол зайд хэрэглэдэг.

Шилэн кабелийг залгах, холбох, гагнах ажиллагаа нь маш нарийн төвөгтэй байдаг. Цахилгаан дохио биш гэрлэн дохио дамжуулдаг учир залгаас нь ямар ч согоггүй, бараг төгс хийгдсэн байх ёстой. Шилэн кабелийн 2 үзүүрийг эхлээд таслан үзүүрлэдэг бөгөөд тусгай төхөөрөмжөөр хайлуулан залгадаг байна. Шилэн кабелийн залгааны зөвшөөрөгдөх унтралтын хэмжээ 0.01 дб байдаг.



Зураг 2.31. Шилэн кабель, бүтэц



Зураг 2.32. Оптик шилэн кабель (Optical fiber)

Оптик шилэн кабелийн давуу талууд:

- Дохионы унтралт бага (0.23дВ/км -аас бага)
- Мэдээллийн зурвасын өргөн ихтэй
- Кабелийн хөндлөн огтлолын хэмжээ бага
- Дахин дамжуулалгүйгээр хол зайд ашиглах боломжтой (100 гаруй км)
- Ашиглалтын хугацаа урт (25-40 жил)
- Өндөр хурдны өргөн зурвасын “triple play” үйлчилгээг явуулах боломжтой
- Цахилгаан соронзоны нөлөөлөл байхгүй
- Олон төрлийн төхөөрөмж холбох боломжтой (PON, SDH, IP, ATM)
- Асар өргөн давтамжийн зурвас.
- Шилэн кабелийн давтамжийн зурвасыг цаашид өргөтгөж болох боловч энэ нь зөвхөн ганц оптик зөөгчөөр хязгаарлагддаггүй.
- Оптик шилэн кабель нь шилээр хийгддэг учраас цахилгааны тусгаарлагч гэж үзэж болох ба металл кабель шиг газардуулга, интерфэйсийн бэрхшээл байхгүй. Оптик кабелиар цахилгааны аюултай орчинд холбоо зохион байгуулахад нэн зохимжтой. Шилэн кабель богино залгаас болон шалбархай дээр тэсрэх ховхрох зэрэг аюулгүй.
- Дохионы нууцлал маш өндөр; Шилэн кабелиар дамжиж байгаа гэрэл их хэмжээгээр сарнидаггүй (гадагш цацардаггүй) учир дохионы нууцлал маш өндөр.
- Ерөнхий газардуулга шаардагдахгүй
- Температурын өөрчлөлтийг тэсвэрлэх чадвар сайн
- Материалын түүхий эдийн олдоц ихтэй.
- Уян хатан ба бат бөх хийцтэй: Хамгаалах бүрхүүлүүд шаардлагатай боловч, шилэн кабель маш өндөр хүчний элементтэй хийгдэж болно. Шилэн кабель нь бага радиустай нугарч тахийж болох ба гэмтэлгүйгээр эвхэх боломжтой. Үүнээс гадна хадгалах, тээвэрлэх, суурилуулахад зэс кабельтай харьцуулахад давуу талтай.
- Галд тэсвэртэй
- Ашиглалтыг технологийн горимын дагуу явуулахад найдваржилт өндөртэй

Дутагдалтай талууд:

- Интерфэйсийн төхөөрөмжийн үнэ өртөг их
- Нарийн мэргэжлийн инженер техникийн ажилтнууд шаардагддаг
- Лазерын техниктэй ажилладаг тул хөдөлмөр хамгааллыг нарийн сахих шаардлагатай.

Гол зүрхэвч ба түүний бүрхүүл хоёрыг бага зэрэг ялгаатай хольцтой нэг цогц кварцан биет хэлбэрээр үйлдвэрлэдэг ба нэг нэгээс ялгаж салгах боломжгүй юм. Шилэн утас нь ямар нэгэн нүх сүвгүй бүхэлдээ цул бүтэцтэй байна. Шилэн кабель нь хүний үсний диаметртэй ойролцоо цэвэр шилээр хийгдсэн байдаг.

Нэвтрүүлэх байгууламж: Энд цахилгаан дохиог гэрлэн дохио болгон хувиргах процесс явагдах бөгөөд лазер, гэрэл цацруулагч диод гэх мэт гэрэл үүсгэгчидийн тусламжтайгаар гүйцэтгэдэг. Удирдлагын төхөөрөмж нь оролтын дохиог гэрэл үүсгэгчийг удирдах боломжтой тодорхой хэлбэр бүхий дохио болгон хувиргадаг (зураг 2.32).



Зураг 2.33. Оролтын дохионы гэрэл үүсгэгчийг удирдах

Удирдах төхөөрөмжөөс ирж байгаа гүйдлийг гэрлэн дохио болгон хувиргах гэрэл үүсгэгчээр гэрэл цацруулах диод ба лазер ашигладаг. Лазер нь диодтай харьцуулахад монохромат, когерент чанар сайтай, хөндлөн дисперс багатай гэрэл цацруулдаг бөгөөд диодаас хурдан ажиллагаатай Харин гэрэл цацруулагч диод нь ашиглахад хялбар, үнэ хямд байдаг. Оптик холбоонд гэрэл үүсгэгчээр хэрэглэж байгаа диод ба лазер нь хүний нүдэнд үл үзэгдэх эрчим ихтэй инфра улаан туяаг цацруулдаг. Энэ туяа хүний нүдэнд муу нөлөөтэй учир асаалттай байгаа гэрэл үүсгэгч буюу гэрэл үүсгэгчид холбоотой шилэн кабел руу эгц харж болохгүй. Хэрвээ харах шаардлага гарсан үед заавал тэжээлээс салгаж байж харах хэрэгтэй. Гэрэл үүсгэгчийн характеристикийг дараах хүснэгтэд харуулав.

Хүснэгт 2.8. Гэрэл үүсгэгчийн үзүүлэлт

Параметр	Диод	Лазер
Гаралтын чадал	Бага	Өндөр
Хурд	Бага	Өндөр
Гаралтын аператур	Өндөр	Бага
Спектрийн характеристик	Өргөн	Нарийн
Хэрэглээ	Энгийн хялбар	Нарийн
Ашиглалтын хугацаа	Маш урт	Урт
Үнэ өртөг	хямд	Үнэ өртөг өндөр

Хурд: Оптик системийн нэвтрүүлэх зурвасын өргөний шаардлагыг хангаж байхын тулд үүсгэгчийн залгах ба салгах хурд маш өндөр байх ёстой. Үүсгэгчийн хурд сигналын тогтворжих хүртлээ өрнөх ба буцаж унах хугацаагаар тодорхойлогдоно. Өрнөх хурд лазер 1 нс-ээс бага, гэрлэн диодын хувьд хэдэн наносекунд байна. Энэ хугацаанаас ажлын зурвасын өргөн хэрхэн хамаарахыг томъёогоор үнэлдэг.

$$BW = 0.35/t$$

Ашиглалтын хугацаа: Үүсгэгчийн ашиглалтын баталгаат хугацаа сая цаг байдаг. Үүнээс хойш хагас дамжуулагч кристалл дахь дефектын тоо өссөний улмаас үүсгэгчийн гаралтын чадал нь багасдаг. Үүсгэгчийн баталгаат хугацаа гаралтын чадалын түвшин 50% хүртэл буурах хугацаагаар тодорхойлогдоно.

Ашиглалтын боломж: Лазер нь гэрлэн диодоос оптик шинжээрээ давуутай боловч нарийн төвөгтэй, үнэ ихтэй, ашиглалтын хугацаа нь гэрлэн диодоос богино байдаг. Лазерын үүсгүүр диодоос илүү нарийн ажиллагаатай удирдах төхөөрөмж шаарддаг. Лазерын гаралтын чадал нь температур хэлбэлзэхэд мэдэгдэхүйц өөрчлөгдөнө. Иймээс температурын өөрчлөлтөнд гаралтын чадлыг тогтмол түвшинд барьж байхын тулд удирдах гүйдлийг тохируулагч тусгай төхөөрөмж шаарддаг.

Холболт: Оптик системд үүсгэгчийг холбож өгөхдөө шилэн кабель руу энергийг алдагдалгүйгээр дамжуулах бүх боломжийг хангаж өгдөг. Үүний тулд үүсгэгч ба шилэн кабелийн оптик шинжүүд нийцэж байх ёстой.


Хүлээн авах байгууламж: Хүлээн авсан гэрлэн дохиог эргүүлээд цахилгаан дохио болгон хувиргах зориулалттай хэсэг. Хүлээн авах байгууламж нь дотроо детектор, гаралтын төхөөрөмж гэсэн 2 хэсгээс тогтоно. Детектор нь дохиог хувиргах, гаралтын төхөөрөмж нь шаардлагатай үед дохиог өсгөх, хэлбэрийг өөрчлөх үүрэг гүйцэтгэнэ.

Хүснэгт 2.9. Стандарт шилэн кабелийн үзүүлэлтүүд


Жил	Байгуулга	Үр дүнтэй хурд	WDM суваг	Нэг сувгийн хурд	Тархах зай
2009	Alcatel-Lucent	15.5 Тбит/сек	155	100 Гбит/сек	7000 км
2010	NTT	69.1 Тбит/сек	432	171 Гбит/сек	240 км
2011	NEC	101.7 Тбит/сек	370	273 Гбит/сек	165 км
2011	КИТ	26 Тбит/сек	>300		50 км
2016	BT ба Huawei	5.6 Тбит/сек	28	200 Гбит/сек	140 км
2016	Nokia Bell Labs, Deutsche Telekom T-Labs ба Technical University of Munich	1 Тбит/сек	1	1 Тбит/сек	
2016	Nokia-Alcatel-Lucent	65 Тбит/сек			6600 км
2017	BT ба Huawei	11.2 Тбит/сек	28	400 Гбит/сек	250 км

Хүснэгт 2.10. Долгионы уртын хамрах хүрээ

Зурвас	Тодорхойлолт	Долгионы уртын хамрах хүрээ
О зурвас	original	1260-аас 1360 нм хүртэл
Е зурвас	extended	1360-аас 1460 нм хүртэл
S зурвас	short wavelengths	1460-аас 1530 нм хүртэл
С зурвас	conventional ("erbium window")	130-аас 1565 нм хүртэл
L зурвас	long wavelengths	1265-аас 1625 нм хүртэл
U зурвас	ultralong wavelengths	1625-аас 1675 нм хүртэл



Зураг 2.34. Оптик холболт



Зураг 2.35. Монгол улсын шилэн кабелийн сүлжээ

2.5.3.1. Шилэн кабель ашиглан мэдээлэл дамжуулах, хүлээн авах:

Анх 1949 онд Наушкаас Улаанбаатар хооронд төмөр замыг барьж ашиглалтанд оруулахад төмөр замын холбооны аж ахуй үүсэж хөгжсөн түүхтэй. 1951 онд Дохиолол холбооны алба, түүний харьяа ангиуд байгуулагдсан ба энэ цагаас эхлэн уг алба нь төмөр замын холбоо, мэдээллийн салбарыг хариуцан галт тэрэгний хөдөлөөнийг найдвартай холбоо мэдээллээр хангахын тулд техник технологио байнга шинэчлэн сайжруулсаар ирсэн.

1995 оноос төмөр замын холбооны аж ахуйд тоон технологи нэвтэрч эхэлсэн бөгөөд Siemensийн Hicom 392 ЭАТС-ыг Улаанбаатар, Дархан, Зүүнхараа, Чойр, Сайншанд өртөөдөд суурилуулаж ашиглалтанд өгсөн. 2000 оноос нэвтрүүлэх хүчин чадлыг дээшлүүлэх, холбоо мэдээллийн орчин үеийн шинэ техник, технологи нэвтрүүлэх зорилгоор УБТЗ холбоо, мэдээллийн салбартаа хөрөнгө оруулалт хийж улсын хойт хилээс урд хил хүртэл төмөр замын дагуу нийт 1400 км гаруй урт шилэн кабелийн сүлжээ тавигдан, Төмөр замын шилэн кабель ашиглалтанд орсноор төмөр замын дагуу хот суурин газруудад Simens Hicom ЭАТС-д холбогдож төмөр замын үндсэн сүлжээ тоон технологид бүрэн шилжсэн. 2000 онд ашиглалтанд орсон энэхүү сүлжээ Улсын нийслэлээс гадна 5 аймаг, 21 сумыг дайран өнгөрч, 8 хот суурин газраар Цахилгаан холбоо компанийн холбооны сүлжээтэй шууд холбогдсон. Монгол улсын шилэн кабелийн, анхны сүлжээ болсон, энэ нь зөвхөн Төмөр Замын тээврийн технологид хэрэглэгдээд зогсохгүй Монголын холбоо мэдээллийн үйлчилгээ эрхлэгч компаниудын мэдээлэл холбооны үйлчилгээг орон нутагт хүргэхэд ашиглагдаж байна.

2002 онд ТЗ-ын холбоо, мэдээллийн нийтийн үйлчилгээг өргөжүүлэх зорилгоор Бизнес Үйлчилгээний Рэйлком төвийг байгуулсан байна. Энэ үеэс эхлэн гадаадын холбоо, мэдээллийн компаниудтай идэвхтэй үйл ажиллагаа явуулж ОХУ-ын Транстелеком компани, БНХАУ-ын Чайна Юником, Чайна Нэтком, Чайна Тьетонг компаниудтай хамтын ажиллагааны хэд хэдэн санамж бичиг, гэрээ хэлэлцээр байгуулснаар Төмөр замын холбоо нь Ази-Европ тивүүдийг холбосон сүлжээ хоорондын харилцан холболттой болж улс хоорондын газрын гарц бүхий Монгол улсын анхдагч шилэн кабелийн сүлжээ эзэмшигч үйлгээний оператор болсон.

2003 оноос Төмөр замын дотоод технологийн шуурхай холбоог тоон системд шилжүүлэх, төмөр замын бүх өртөө зөрлөгийг хамарсан тоон технологийн дэд сүлжээг байгуулж эхэлсэн ба 2003-2006 онуудад төмөр замын бүх өртөө зөрлөгт буюу нийт 73 газарт ОХУ -ын “Морион” нийгэмлэгийн PDH системийн дамжуулах төхөөрөмж, технологийн тусгай зориулалтын ОГМ төхөөрөмжийг суурилуулсан.

2004 онд ОХУ-ын Транстелеком, БНХАУ-ын Чайна Юником, МТЗ-ын гурван талын хамтын ажиллагааны үр дүнд эх газрын оптик шилэн кабелийн “ЕКМС” буюу Европ-Орос-МонголХятад гэсэн утгаар нэрлэгдсэн шинэ сүлжээ ашиглалтанд орж Төмөр замын шилэн кабелийн сүлжээгээр холбоо, мэдээллийн улс хоорондын транзит урсгал нэвтэрч эхэлсэн юм. "УБТЗ" ХНН-ийн технологийн зориулалттай оптик шилэн кабелийн сүлжээ

- "УБТЗ"ХНН-ийн шилэн кабелийн сүлжээ нь 1998-2000 онд японы засгийн газрын хөнгөлөлттэй зээлээр нийт 1,773 сая иен буюу тухайн ханшаар 17,606 сая төгрөгийн өртөгөөр барьж байгуулсан.
- Анхны дамжуулах системийн хүчин чадал STM-1 буюу 155 Мбит/сек байв.
- УБТЗ-ын өөрийн хөрөнгө оруулалтаар өргөтгөл хийж мэдээлэл дамжуулах чадвар 45 Гбит/сек орчим болсон байна.

"УБТЗ"ХНН-ийн технологийн зориулалттай оптик шилэн кабель нь 12 шөрмөстэй, нэг моодын G.652 маркийн кабель юм. Үүнээс 4 шөрмөсийг "Мэдээлэл, Холбооны Сүлжээ"ТӨК эзэмшдэг, үлдсэн 8 шөрмөсийг төмөр замд ашиглаж байна.

Хүснэгт 2.11. "УБТЗ"ХНН-ийн технологийн зориулалттай оптик шилэн кабелийн хэрэглээ болон дамжуулах төхөөрөмжүүд


Судлын дугаар	Судлын өнгө	төхөөрөмж	тайлбар
1	Хөх	STM-4 үндсэн	Технологийн холбоонд ашиглагдаж байгаа. Хэрэглэгийн (Access Layer) түвшний төхөөрөмжийн цагираган хамгаалалт үүсгэдэг
2	Шар	STM-4 үндсэн	
3	Ногоон	STM-4 нөөц	Жемнет ХХК -тай харилцан шөрмөс солилцох зарчмаар 1+1 оптик кабелийн автомат хамгаалалт зохион байгуулсан
4	Улаан	STM-4 нөөц	
5	Чер Ягаан		Төрийн өмчит сүлжээ компани ашиглаж байна.
6	Цагаан		
7	Бор	OSN-500	Төмөр замын бүх өртөө зөрлөг, нэгжүүдрүү холбогдсон үндсэн үйлчилгээ буюу (Access Layer) түвшний төхөөрөмжийн цагираган хамгаалалттай сүлжээ Дээд талын түвшин болох STM-4 (Aggregate Layer) системээр цагираган холболт үүсгэж хамгаалагдсан
8	Саарал	OSN-500	
9	Ягаан		Төрийн өмчит сүлжээ компани ашиглаж байна.
10	Улбар шар		
11	Цайвар цэнхэр	DWDM	Бизнесийн зориулалттай транзит урсгал явуулж байгаа. Мөн төмөр замын мэдээллийн сүлжээнд Сүхбаатар-Улаанбаатар-Замын-Үүд гэсэн цагариган хамгаалалт үүсгэхээр зохион байгуулагдсан байгаа.
12	Хар	DWDM	

2014 оны 01-р сарын 22-ны өдөр Төмөр зам, далайн тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газраас ирүүлсэн "Санал авах тухай" 8/310 албан тоотод хавсралт мэдээллүүдийг үндэслэн "УБТЗ" ХНН-ийн 8 шөрмөснөөс **Бор болон Саарал өнгийн шөрмөсүүдийг ашиглах боломжтой** гэж үзсэн. Цаашдаа "УБТЗ" ХНН-тэй хамтран шилэн кабель, шөрмөс ашиглалтыг төрийн үйлчилгээнд эзэмших судалгаа хийгдэх шаардлагатай.

Хүснэгт 2.12. "УБТЗ"ХНН-ийн технологийн зориулалттай шилэн кабелиг ашиглаж буй байгууллагууд

Шөрмөсний өнгө	Ашиглаж буй газар	тайлбар
Хөх	УБТЗ-ын технологийн холбоо, холболтын байгууламж.	Мэдээллийн сүлжээний үндсэн шөрмөсүүд болно.

Шар		
Ногоон	“Жемнет” ХХК-тай харилцан шөрмөс солилцох зарчмаар 1+1 шилэн кабелийн автомат хамгаалалт зохион байгуулсан.	Аюулгүй байдлын хүрээнд Үл тасалдал буюу шилжүүлэн залгах шөрмөсийн хамтын ажиллагааны гэрээгээр зохицуулагддаг.
Улаан		
Чер ягаан	“Мэдээлэл, холбооны сүлжээ” ТӨК эзэмшиж байгаа	“Төмөр замын дагуух шилэн кабелийн сүлжээний ашиглалтыг сайжруулах талаар
Цагаан		
Бор	Төмөр замын тээвэртэй холбоотой бүх хэрэглэгчдийг холбох зориулалттай хэрэглэгчийн түвшний систем юм. Төмөр замд шинэ өртөө зөрлөг нэмэгдэх, төмөр зам дагуу ямар нэгэн объектыг сүлжээнд холбох бол энэхүү түвшинд холбоно.	80 дугаар тогтоолоор төмөр замын дагуух 1402 км шилэн кабелийн ашиглагдахгүй байсан 4 шөрмөсийг төмөр замын хэрэг эрхлэх газраас Шуудан, цахилгаан холбооны газрын эзэмшилд шилжүүлсэн.
Саарал		
Ягаан	“Мэдээлэл, холбооны сүлжээ” ТӨК эзэмшиж байна.	Аж ахуйн тооцоотой төрийн өмчит үйлдвэрийн газар үйл ажиллагаандаа ашиглах “Төмөр замын дагуух шилэн кабелийн сүлжээний ашиглалтыг сайжруулах талаар авах зарим арга хэмжээний тухай” 80 дугаар тогтоолоор төмөр замын дагуух 1402 км шилэн кабелийн ашиглагдахгүй байсан 4 шөрмөсийг Төмөр замын Хэрэг эрхлэх газраас Шуудан, цахилгаан холбооны газрын эзэмшилд шилжүүлсэн.
Улбар шар		
Цэнхэр	Төмөр замын сүлжээнд Сүхбаатар-Улаанбаатар-ЗамынҮүд гэсэн цагираган хамгаалалт үүсгэхээр зохион байгуулагдсан.	Бизнесийн зориулалттай транзит урсгал явуулж байна.
Хар		



Зураг 2.36. "Санал авах тухай" 8/310 тоот албан бичиг

2.5.4 Өртөөдөөс мини удирдлагын серверлүү дамжих өгөгдлийн тооцоо

Өгөгдлийн менежментийн систем буюу мини удирдлагын төврүү хөдлөх бүрэлдэхүүний хяналтын шийдлүүдийн сонголтоос шалтгаалан вагон өгөгдлийн хэмжээ харилцан адилгүйгээр илгээгдэх бөгөөд тодруулбал “VIS”-д нэг вагоны өгөгдөл 128 бит байх бол “OCR” CAMERA-д 6 мегабайт зурган мэдээлэл илгээгддэг.

Сонгогдсон өртөөдийн вагон урсгалын мэдээллийг нэгдсэн зурмагт үндэслэн тэгш, сонгой чиглэлд өгөгдлийн урсгалыг тооцсон, “VIS” системээр өдөрт 4’117.760 бит буюу 514’720 байт мэдээлэл нийт 12 “RF” уншигчаас секундэд 74,488 байт мэдээлэл өгөгдлийн менежментийн системрүү илгээнэ. Жилд 183’469.531 Кбайт мэдээлэл серверт хадгалагдана. Тэгвэл “OCR” системд өдөрт 96’510 мегабайт мэдээлэл нэг камернаас, нийт 42 камернаас 4’053.420 мегабайт мэдээлэл, секундэнд 46,9 мегабайт мэдээлэл өгөгдлийн менежментийн системрүү илгээгдэнэ. Жилд 268,754.196 терабайт мэдээлэл серверт хадгалагдана.

			Нэг галт тэргэнд байх вагон тоо - 65	Нэг галт тэргэнд байх вагон тоо - 100	Өртөөний Нийт галт тэргэнд байх вагон тоо	Өртөөний нийт вагоны нийт вагоны дата /Битээр 1 өдөрт/	Өртөөний нийт вагоны нийт вагоны дата /Битээр 1 өдөрт/	нийт вагоны дата /Байгаар 1 өдөрт/	нийт вагоны дата /Байгаар 365 өдөрт/	нийт вагоны дата /Кбайгаар 365 өдөрт/	нийт вагоны дата /Мбайгаар 365 өдөрт/
Өртөөний нэрс	Тэгш	Сондгой	Тэгш	Сондгой	Нийт	Вагон дугаар дата	2 уншигчын дата	2 уншигчын дата	2 уншигчын дата	2 уншигчын дата	2 уншигчын дата
1 Сүхбаатар	18	13	1170	1300	2470	316160	632320	79040	28849600	28173.4375	27.51312256
2 Цагаанхаалга	4	4	260	400	660	84480	168960	21120	7708800	7528.125	7.35168457
3 Толгойт	24	18	1560	1800	3360	430080	860160	107520	39244800	38325	37.42675781
4 Улаанбаатар	26	21	1690	2100	3790	485120	970240	121280	44267200	43229.6875	42.2164917
5 Сайншанд	22	17	1430	1700	3130	400640	801280	100160	36558400	35701.5625	34.86480713
6 Замын-Үүд	15	17	975	1700	2675	342400	684800	85600	31244000	30511.71875	29.79660034
7 Нийт	109	90	7085	9000	16085	2058880	4117760	514720	187872800	183469.5313	179.1694641

Зураг 2.37. “VIS” систем ашиглан өртөөдөөс илгээх өгөгдлийн хэмжээ

Full HD 1920*1080 2 Мегапикселийн хүчин чадалтай камераар нэгж вагоны дугаарын дүрсийг авахад үүсэх файлын хэмжээ 2 МП*(color depth 24 bit/8 bit) = 6 Мегабайт гэж тооцоолов.											
1 вагоны дугаар = 1 вагоны jpg зураг = 6 Мегабайт											
			Нэг галт тэргэнд байх вагон тоо - 65	Нэг галт тэргэнд байх вагон тоо - 100	Өртөөний Нийт галт тэргэнд байх вагон тоо	1 камерын дата*нийт вагон /Мегабайгаар өдөрт/	1 камерын дата*нийт вагон /МБ-аар 365 өдөрт/	1 камерын дата*нийт вагон /ГБ-аар 365 өдөрт/	8 камерын нийт вагоны дата /ГБ-аар 1 өдөрт/	8 камерын нийт вагоны дата /ГБ-аар 365 өдөрт/	8 камерын нийт вагоны дата /Терабайгаар 365 өдөрт/
Өртөөний нэрс	Тэгш	Сондгой	Тэгш	Сондгой	НИЙТ	Өртөөний дата	Өртөөний дата	Өртөөний дата	Өртөөний дата	Өртөөний дата	Өртөөний дата
1 Сүхбаатар	18	13	1170	1300	2470	14820	5409300	5282.519531	118560	42260.15625	41.26968384
2 Цагаанхаалга	4	4	260	400	660	3960	1445400	1411.523438	31680	11292.1875	11.02752686
3 Толгойт	24	18	1560	1800	3360	20160	7358400	7185.9375	161280	57487.5	56.14013672
4 Улаанбаатар	26	21	1690	2100	3790	22740	8300100	8105.566406	181920	64844.53125	63.32473755
5 Сайншанд	22	17	1430	1700	3130	18780	6854700	6694.042969	150240	53552.34375	52.29721069
6 Замын-Үүд	15	17	975	1700	2675	16050	5858250	5720.947266	128400	45767.57813	44.69490051
7 Нийт	109	90	7085	9000	16085	96510	35226150	34400.53711	772080	275204.2969	268.7541962


Зураг 2.38. “OCR” системд өртөөдөөс илгээх өгөгдлийн хэмжээ

2.6 Ач холбогдол

2.6.1 Галт тэрэгний бүрэлдэхүүн хүлээн авах технологийн процесс




ГАЛТ ТЭРЭГНИЙ БҮРЭЛДЭХҮҮН ӨРТӨӨД ХҮЛЭЭН АВАХ ПРОЦЕСС



2.6.2 Галт тэргийг өртөөнөөс явуулах процесс


Галт тэргийг өртөөнөөс явуулах процессыг зураг 2.39-д харуулав. Т хугацаанаас 0 минут хооронд галт тэрэгний төлөвлөлт, 0 минутаас 140 минутын хооронд галт тэрэгний байршил болон хөдөлгөөнийг харуулав. Техник үйлчилгээний газар (ТҮГ)-ын үзлэг бүрэлдэхүүний урт, группын зэрэглэлээс хамааран үргэлжлэх хугацаа өөр өөр байна. 60-аас дээш хөдлөх бүрэлдэхүүнд I групп үзлэг хийхээр 137 минут үргэлжилсэн бол 30-аас доош хөдлөх бүрэлдэхүүнд 94 минут зарцуулагдсаныг диаграммаас ажиглаж болон. Энэ хугацаанд вагон бичигч, техконтрщик параллель ажил хийж дууссан байна



Зураг 2.40. Галт тэргийг өртөөнөөс явуулах процесс

2.6.3. Төмөр замын мэдээлэл солилцоо, ашиглагдах холбооны төхөөрөмжүүд болон программ хангамж

Өртөөдөд мэдээлэл солилцоог зөв дэс дараалалтай, хурдан шуурхай явуулах тусам хоногийн биелэлтийг төлөвлөснөөр биелүүлэх, ажлын бүтээмжийг сайжруулах, багаар ажиллах чадварыг дээшлүүлэх, ажлын ачааллыг урьдчилан төлөвлөх, ажлын эрсдэлийг бууруулах гэх мэт давуу талтай. Өнөө үед төмөр замд ашиглагдах программ хангамж (НАТУРКА, АТМС, БТУКС, Эстопресс) болон мэдээлэл дамжих хэлбэрийг зураг 2.40-д харуулав. Зурагт өртөөний товарын контор, оператор, техконтрщик, өртөөний мэдээлэгч, статистик бүртгэлийн мэдээлэгчид өөр өөрсдийн хариуцаж авсан ажлын хүрээнд дээрх программуудад нэвтрэх эрх авч мэдээлэл шинэчлэх, мэдээлэл татаж авах, мэдээлэл шинээр оруулах үүрэгтэй.



Зураг 2.41. Төмөр замын мэдээлэл солилцоо, ашиглагдах холбооны төхөөрөмжүүд болон программ хангамж

Харин өртөөдийн хөдөлгөөн цех болон ачаа тээврийн цехийн ажилчдын мэдээлэл солилцох журмыг схемийн доод хэсэгт харуулав. Техконторщик өртөөдөд (ачсан, буусан вагон, хүлээн авсан, явуулсан галт тэрэг г.м) ихээхэн хэмжээний гүйцэтгэсэн ажлын мэдээллийг галт тэрэгний биечилсэн бүртгэх хуудас болгон хоёр хувь хэвлэж өртөөний жижүүрт нэг хувийг, үлдсэн хувийг техник мэдээлэгчид хүргүүлнэ. Галт тэрэгний биечлэн бүртгэх хуудсыг АТМС болон НАТУРКА программд байгаа мэдээллийг тулгуурлан хэвлэдэг. НАТУРКА программ дээр тухайн вагоны суурь өгөгдлүүдийг (эзэмшигч төмөр зам, вагоны дугаар, голын тоо, вагоны төрөл, вагоны савны жин, томьёолсон урт) жилд нэг удаа бодит байдалтайгаа тулгасан байдаг учир техконторщик НАТУРКА програм дээр хадгалагдсан суурь өгөгдлүүдийг ашиглан программд галт тэрэгний найруулга хийж вагон бичигчдэд бодит байдалтай тулгаж ажилладаг. Харин ачаа болон ачаа хүлээн авагчийн мэдээлэл (Ачааны нэр, жин, ачааны хүрэх өртөө, ачаа хүлээн авагч, ачаа буулгах салбар зам, тээврийн гэрээ хийгдсэн огноо)-тэй холбоотой өгөгдлийг АТМС программд товарын контор шивж оруулна.


Товарын контор захиалагчаас ачаа тээврийн үйлчилгээний цахим систем (БТУКС) ашиглан захиалгын тухай мэдээллийг авна. Зураг 2.41-д галт тэрэгний биечилсэн хуудас (ДУ-1)-ын зургийг харуулав.

Өртөөдийн мэдээлэгч нь техникийн конторшикоос хүлээн авсан биечилсэн хуудсыг ирсэн, явсан цагаар нь цэгцлэн орон нутгийн сул зогсолт, маягтад галт тэрэг бүрээр нь бүртгэж, ачилт буулгалтын мэдээг бичиг баримт, вагон хуудсаар нь тулган шалгана. Ачааны паркийн хоногийн тайланг /маягт ДО/ галт тэрэгний биечилсэн хуудас /ДУ-1/ үндэслэн гаргана. Техникийн гэмтэлтэй вагонуудыг ВУ-23, ВУ-26, замын нөөцөд тавьсан вагонуудыг ДУ-6, ДУ-7 маягтаар хөтөлнө. Хоосон вагоны мэдээг ДО-2 тус тус гаргаж ачааны паркийн вагоны сул зогсолтын мэдээг дугаарын аргаар хөтлөн орон нутаг, дамжин өнгөрөх ажиллагаатай, ажиллагаагүй байдлаар нь тус

тус мэдээллийг нэгтгэж Статистик бүртгэл мэдээллийн технологийн төвд 18:30 цагаас өмнө стоппресс программ ашиглан дамжуулдаг.

2.6.4. Ашиглалтын ажлын үзүүлэлтүүдийн мэдээллийг автоматжуулах

Бид “Дэлхий даяар мэдээллийн технологи хурдацтай хөгжиж бүх мэдээлэл тоон технологид шилжиж, автоматажсан” зууны үед амьдарч байна. Ялангуяа төмөр замд мэдээллийн урсгал хурдан шуурхай, үнэн зөв дамжуулах зайлшгүй шаардлагатай. Тийм учраас бид төмөр замын суурь өгөгдлүүдийг радио давтамж тодорхойлох /RFID/ аргаар орон нутгийн тээврийн вагоныг, камер /OCR/ ашиглан транзит тээврийн вагонуудын бодит цагийн мэдээллийг тодорхойлсноор RRIS²⁴ бие болгох судалгааны ажил хийж байгаа билээ. Төмөр замын мэдээлэл солилцооны өнөөгийн байдлыг RRIS системтэй харьцуулалт хийж Зураг 2.42-д харуулав.



Зураг 2.42. Төмөр замын мэдээлэл солилцоо бүдүүвч схем (өнөөгийн байдал болон RRIS)

2.6.5. Хүний нөөц талаас хялбарчлах

